

**Төрийн Албан Хаагчдад Зориулсан МХХТ-ийн
Суурь Мэдлэгийн Академи**

МОДУЛЬ 2

Интернэтийн засаглал

Ан Пен Хуа

Төрийн албан хаагчдад зориулсан МХХТ-ийн суурь мэдлэгийн академийн модулиуд

Модуль 5: Интернэтийн засаглал

Энэ номыг “Creative Commons Attribution 3.0 License” тусгай зөвшөөрлийн хүрээнд хэвлэсэн болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://creativecommons.org/licenses/by/3.0/> үзнэ үү.

Энэхүү номонд тусгагдсан санал бодол, тоо баримт ба тооцоолол нь зохиогчийн байр суурийг илэрхийлсэн бөгөөд эдгээрийг НҮБ-ын байр суурийг илэрхийлсэн буюу НҮБ-ээс зөвшөөрөгдсөн баримт бичиг гэж ойлгож болохгүй.

Үүнд багтсан танилцуулгууд болон тэдгээрийн зохион байгуулалт нь НҮБ-ийн Нарийн бичгийн дарга нарын газрын зүгээс ямар нэгэн улсын хууль ёсны статус, нутаг дэвсгэр, хот суурин болон газар нутаг, эрх баригчид, тэдгээрийн хил хязгаартай холбоотойгоор баримтлаж буй үзэл баримтлалын хүрээнд илэрхийлээгүй болно.

Компаниудын нэр, арилжааны бүтээгдэхүүнүүдийн нэрийг дурдсан нь НҮБ-ийн үзэл бодлын хүрээнд тусгагдаагүй болохыг анхаарна уу.

НҮБ-ын Хөгжлийн Төлөөх Мэдээлэл, Харилцаа Холбооны Технологийн Ази,
Номхон Далайн Бүсийн Сургалтын Төв

Хаяг: Bonbudong, 3rd floor Songdo Techno Park
7-50 Songdo-dong, Yeonsu-gu, Incheon City
Republic of Korea

Утас: +82 32 245 1700002

Факс: +82 32 245 7712

И-мэйл: info@unapcict.org

Веб сайтын хаяг: <http://www.unapcict.org>

Copyright©UN-APCICT 2009

ISBN: 978-89-955886-4-2 [94560]

Хэвлэлийн эхийг Scandinavian Publishing Co Ltd, Studio triangle компани бэлтгэж,
Бүгд Найрамдах Солонгос Улсад хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

21 дүгээр зууныг даяаршиж буй дэлхий дээр амьдарч байгаа хүн төрөлхтөний хараат бус, бие даах чадварыг улам бүр нэмэгдүүлсэн гэж тооцдог. 21-р зуун нь шинэ технологийн үр өгөөжийг сая сая хүмүүст амсуулж, ард иргэдийн амьдралыг эрс сайжруулж, ядруурлыг бууруулж чадах мэдээлэл, мэдлэгийн хүртээмжийг өргөжүүлэх бололцоог нээсэн цаг хугацаа билээ. Гэхдээ хараат бус байдал нь дангаараа бус хүн бүрт нээлттэй байх тогтвортой хөгжлийн төлөөх үнэ цэнэ, зорилт, эв нэгдлийн хамт өсөн нэмэгдэх бололцоотой.

Сүүлийн жилүүдэд Ази, Номхон далайн бүс нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн хувьд илүү давуу хөгжилтэй бүс нутаг болон хөгжиж байна. ОУЦХБ-ын тооцоолсноор тус бүс нутгийн телефон шугамын тоо хоёр тэрбумаас давж, хөдөлгөөнт холбооны хэрэглэгчийн тоо 1.4 тэрбумд хүрсэн үзүүлэлт гарчээ. 2008 оны хагас жилийн байдлаар дэлхийн нийт хөдөлгөөнт холбооны хэрэглэгчдийн дөрөвний нэг хувийг Хятад болон Энэтхэг улс эзэлсэн тооцоо гарсан. Дэлхийн интернэт хэрэглэгчийн 40 хувийг Ази, Номхон Далайн бүс хамрах бөгөөд интернэтийн өргөн зурвасын дэлхийн зах зээлийн 39 хувийг эзэлж байгаа нь хамгийн том зах зээл гэсэн үг юм.

Технологийн ололт, амжилтуудын үр дүнд тоон хуваагдал арилсан болов уу гэж таамаглахад хараахан арилж амжаагүй байгаа гэсэн хариулт гарч ирж байгаа нь харамсалтай. МНДДХУ буюу Мэдээлэлжсэн Нийгмийн Дэлхийн Дээд Уулзалт /МНДДУ/ 2003 онд Женев хотноо зохион байгуулагдснаас хойшхи таван жилийн нөхцөл байдлыг авч үзэхэд тус бүс нутаг технологийн ололт амжилтаар тэргүүлж байсан хэдий ч хүн амын олонх нь ялангуяа ядуу иргэд харилцаа холбооны үндсэн үйлчилгээг авч чадаагүй хэвээр байна.

Тус бүсийн 25 орон буюу голцуу жижиг арлын хөгжиж байгаа орнууд болон далайд гарцгүй орнуудын 100 хүнд ноогдох интернэт хэрэглэгчийн тоо нь 10 хүрэхгүй, эдгээр хэрэглэгчид нь ихэвчлэн томоохон хотод амьдардаг хотын оршин суугчид байхад нөгөө талаас тус бүсийн хөгжингүй орнуудын 100 хүнд ноогдох интернэт хэрэглэгчийн тоо нь 80 гаруй байгаа тооцоо гарчээ. Өргөн зурвасын үйлчилгээний хэрэглээний ялгаа бүр их байна.

Тус бүсийн нийгэм-эдийн засгийн хөгжлийг хангахад МХХТ-ийн чадавхийг ашиглаж, тоон хуваагдлыг арилгахын тулд хөгжиж байгаа орнуудын бодлого боловсруулагчид МХХТ-ийн үйлдвэрлэлийн салбар болон иргэдийн МХХТ-ийн чадварыг хөгжүүлэх түншлэлийг дэмжих, тэргүүлэх ач холбогдол бүхий ажил, арга хэмжээг тодорхойлж, бодлого хэрэгжүүлэх, хууль эрх зүй болон зохицуулалтын орчинг тодорхойлох, төсөв, санхүүг оновчтой хуваарилах шаардлагатай юм.

МНДДУ –ын Үйл ажиллагааны төлөвлөгөөнд “...хүн бүр мэдээлэлжсэн нийгэм болон мэдлэгт тулгуурласан эдийн засгийг ойлгох, оролцох, үр өгөөжийг хүртэхийн тулд шаардлагатай мэдлэг, чадвар эзэмших боломжтой байх ёстой...” гэж тусгасан. Уг төлөвлөгөөнд МХХТ-ийн мэргэжлийн боловсон хүчин, шинжээчдийг олноор нь төрүүлэх зорилгоор олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэхийг уриалсан байдаг.

Энэхүү уриалгын хүрээнд МХХТ-ийн АНДБ-ийн Сургалтын Төвөөс хөгжлийн зорилтод МХХТ-ийг ашиглах сургалтын хөтөлбөр боловсруулсан. Тус хөтөлбөр нь өөр хоорондоо уялдаа холбоотой 8 модулиас бүрдсэн бөгөөд бодлого боловсруулагчдад МХХТ-ийн санал, санаачилгыг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг болох мэдлэг, мэдээлэл өгөх зорилготой юм.

Хөгжлийн төлөөх МХХТ-ийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төв нь НҮБ-ын АНДБ-ийн Эдийн Засаг, Нийгмийн Коммисс-/АНДБЭЗНК/-ын бүсийн 5 байгууллагын нэг билээ. АНДБЭЗНК нь Ази, Номхон далайн бүсэд дүн шинжилгээ, норматив үйл ажиллагаа, чадавхийг бэхжүүлэх, бүс нутгийн хамтын ажиллагаа болон мэдлэг хуваалцах замаар тогтвортой, тэгш хамарсан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилготой юм. НҮБ-ын бусад байгууллагууд, олон улсын байгууллагууд, үндэсний хэмжээний түншүүд, оролцогч талуудтай хамтран АНДБЭЗНК нь Хөгжлийн төлөөх МХХТ-ийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төвөөр дамжуулан энэхүү сургалтын модулиудыг ашиглах, нутагшуулах, орчуулах, төрийн байгууллагуудын дээд болон дунд түвшний ажилтнуудад зориулсан бүсийн болон үндэсний хэмжээний семинаруудаар түгээх үйл явцыг хөхүүлэн дэмжиж, энэхүү үйл явцаар дамжуулан бий болсон чадавхи болон олж авсан мэдлэг нь хөгжлийн зорилтуудад нийцэхүйц МХХТ-ийн үр шим болон бодит үйл ажиллагааг бий болгох зорилготой байдаг юм.

Ноелиин Хэйзер

НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Даргын Орлогч Дарга бөгөөд
АНДБ-ийн Эдийн Засаг, Нийгмийн Коммиссын Гүйцэтгэх Нарийн Бичгийн Дарга

УДИРТГАЛ

Төрийн албан хаагчдад зориулсан МХХТ-ийн суурь мэдлэгийн академи хэмээх цуврал модулийг боловсруулах үйл ажиллагаа нь бидэнд ихээхэн урам зориг өгсөн, бидний нүдийг нээн өгсөн үйл ажиллагаа, томоохон аялал байлаа. Академи нь зөвхөн МХХТ-ийн чадавхийг бэхжүүлэх үйл явцад байгаа орхигдсон зүйлсэд бус мөн иргэдийн оролцоо, үйл явцыг өөриймшүүлэн эзэмших замаар сургалтын хөтөлбөр боловсруулах шинэ арга замыг бий болгох зорилготой билээ.

Академи нь Хөгжлийн төлөөх МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төвийн тэргүүлэх хөтөлбөр бөгөөд бүс нутаг дахь 20 гаруй улсыг хамруулан зохион байгуулсан эрэлт хэрэгцээний үнэлгээний үр дүн, төрийн байгууллагуудын ажилтнууд, олон улсын хөгжлийн нийгэмлэгийн гишүүд, эрдэмтэд болон судлаачидтай хийсэн зөвлөлдөх уулзалтуудын үр дүн; өнөөгийн хэрэглэж буй сургалтын материалын давуу болон сул талуудад хийгдсэн гүнзгийрүүлсэн судалгаа; Хөгжлийн төлөөх МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төвийн бүсийн болон дэд-бүсийн хүрээнд зохион байгуулсан сургалт, семинаруудад оролцогчдын зүгээс модулийн агуулгын хоорондын хамаарал болон үр ашгийн талаар гаргасан саналууд; МХХТ-ийн салбарын олон тооны экспертүүдийн хийсэн судалгаа зэрэг дээр суурилан боловсруулагдсан билээ. Бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан Академийн сургалт/семинарууд нь төрөл бүрийн улс орноос төлөөлөн ирсэн оролцогчдын хооронд мэдлэг, туршлагаа хуваалцах үнэлж баршгүй боломжийг ханган өгсөн бол энэхүү арга хэмжээний хүрээнд Академийн төгсөгчид модулиудыг сайжруулах боломжийг мөн хангаж өгсөн юм.

Академиас гаргасан анхан шатны 8 модулийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, нэвтрүүлэх нь бүсийн хэмжээнд өнөөгийн түншлэлийг бэхжүүлэх, МХХТ-ийн хөгжлийн асуудлаар бодлого боловсруулагч нарын чадавхийг бэхжүүлэх шинэ түншлэлийг бий болгох боломжийг бий болгож байна. Хөгжлийн төлөөх МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төв нь Үндэсний академиудад бүх бодлого гаргагч нарт хүрч ажиллах гол хандлагаа хэрэгжүүлэх зорилгоор 8 модулийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхэд техникийн дэмжлэг үзүүлэх хүсэл эрмэлзлэлтэй байгаа билээ. Хөгжлийн төлөөх МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төв нь төв болон орон нутгийн засаг захиргаатай нэгэн сүлжээнд ажиллаж буй бүс нутгийн болон үндэсний хэд хэдэн сургалтын байгууллагуудтай хамтран ажиллаж тэдгээр нь өөрсдийн хэрэгцээ болон тэргүүлэх чиглэлд нийцүүлэн Академийн модулиудыг ашиглах, нутагшуулах, орчуулах, түгээх чадавхийг нь бэхжүүлдэг юм. Цаашид ч өнөөгийн модулиудыг өргөжүүлэн гүнзгийрүүлэх болон шинээр боловсруулах төлөвлөгөөтэй байгаа юм.

Түүнчлэн Хөгжлийн төлөөх МХХТ-ийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төв нь Академийн боловсруулан гаргаж буй агуулгыг нь бүс нутгийн хэмжээнд илүү өргөн хүрээнд түгээн дэлгэрүүлэх үйл явцыг баталгаажуулахын тулд олон суваг бүхий хандлагыг ашиглаж байна. Академийн агуулгыг бүс нутгийн болон үндэсний академиар дамжуулан нүүр тулсан байдлаар түгээн дэлгэрүүлэхээс гадна Хөгжлийн төлөөх МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төвийн Виртуал академийг байгуулан онлайн зайн сургалтыг бий болгон оролцогч нар сургалтын материалыг өөрийн боломжоор судлах бололцоог мөн хангаад байна. Виртуал академи нь бүх модулиуд, тэдгээрийн дагалдах материалууд болох танилцуулгууд, кейсүүдийг агуулж хялбархан нэвтрэн, ашиглах боломжийг хангасны зэрэгцээ татан авах, дахин ашиглах, өөрийн улсад нутагшуулах, нөхцөл байдалд нийцүүлэх боломжийг мөн хангадаг ба мөн виртуал лекцүүд, суралцах аргачлалууд, агуулга хөгжүүлэх аргачлалууд болон гэрчилгээжүүлэлт зэргийг мөн ханган өгсөн.

Анхан шатны цуврал 8 модуль, тэдгээрийг бүс нутгийн болон үндэсний Академийн сургалт/семинаруудаар түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа нь олон тооны хувьд хүмүүс, байгууллагуудын хичээл зүтгэл, оролцоогүйгээр амжилтад хүрэхгүй байсан юм. Энэхүү боломжийг ашиглан миний бие Академийн төгсөгчид, сургалт/семинаруудад оролцож байсан яамд, сургалтын байгууллагууд, бүс нутгийн болон үндэсний байгууллагуудад талархалаа илэрхийлэхийг хүсэж байна. Эдгээр талууд нь модулиудын агуулгад ихээхэн үнэтэй хувь нэмрийг оруулаад зогсохгүй, хамгийн чухал нь өөрийн улс оронд энэхүү Академийн төлөөлөл болон, энэ талаар нөлөөлөл үзүүлэн өөр өөрийн оронд Академийн курсуудыг нутагшуулахад Ази, Номхон Далайн бүсийн хөгжлийн төлөөх мэдээлэл, харилцаа холбооны технологийн сургалтын төв болон үндэсний болон бүс нутгийн түншлэгч байгууллагуудын хооронд албан ёсны гэрээ байгуулах боломжийг нээн өгсөн билээ.

Түүнчлэн миний бие энэхүү гайхалтай, урам зориг өгсөн аялалд маань өөрийн хувь нэмрийг оруулсан олон тооны хүмүүсийн хүчин чармайлтад талархалаа илэрхийлэхийг хүсэж байна. Тэдний тоонд Академийн төслийн зөвлөх Шахид Ахтар, Редактор Патрисиа Аринто, Хэвлэн нийтлэх менежер Кристин Апикул, бүх зохиогч нар болон Академийн ажилтнууд багтаж буй юм.

Улс орнууд нийгэм- эдийн засгийн хөгжил, Мянганы хөгжлийн зорилтуудад хүрэх, түргэтгэхийн тулд МХХТ-ийн хүний нөөцийн хомсдлыг бууруулах, МХХТ-ийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад тотгорыг бууруулах, МХХТ-ийн хэрэглээг дэмжихэд нь Академи өөр тус дэмийг үзүүлж чадна гэдэгт би бат итгэлтэй байна.

Хьюн-Сук Рии

МХХТХ-ийн АНДБНСТ-ийн захирал
Хөгжлийн төлөөх МХХТ-ийн Ази, Номхон Далайн Бүсийн Сургалтын Төв

ЦУВРАЛ МОДУЛИЙН ТУХАЙ

Өнөөдрийн “Мэдээллийн эрин” буюу мэдээлэлд хүрэх арга замыг хялбарчилж чадсан харилцаа холбооны технологийн шинэчлэл нь бидний аж амьдрал, ажил төрөл болон амралтын арга хэлбэрийг өөрчлөөд байгаа билээ. “Тоон эдийн засаг” буюу “мэдлэгийн эдийн засаг”, “харилцан хамаарал бүхий эдийн засаг” эсхүл “шинэ эдийн засаг” зэргээр нэрлэгдэж буй энэхүү эдийн засаг, улс орны хөгжил нь бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс илүүтэйгээр шинэ бүтээлч санааг зохион бүтээхэд шилжин өөрчлөгдөж буй өөрчлөлтөөр тодорхойлогдох болсон. Энэ нь эдийн засаг болон нийгмийн хөгжилд МХХТ-ийн гүйцэтгэж буй үүрэг өсөн нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Үүний үр дүнд дэлхийн улс орнууд, тэдгээрийн засгийн газар нь хөгжлийн зорилтуудыг хангахын тулд МХХТ-ийг ашиглах чиглэлээр түлхүү анхаарах болсон. Тэдгээр засгийн газруудын хувьд МХХТ-ийн үйлдвэрлэл эсхүл эдийн засгийн салбарыг зөвхөн хөгжүүлэхэд бус түүнчлэн эдийн засаг, улс төр болон нийгмийн хөгжлийн өсөлтийг хангахад МХХТ-ийн хэрэглээ чухал үүрэг гүйцэтгэж байгаа нь ажиглагдсан.

Гэхдээ МХХТ-ийг хөгжүүлэх бодлогыг тодорхойлоход засгийн газрууд зарим нэг хүндрэл бэрхшээлтэй тулгардгийн нэг нь бодлого боловсруулагч нар улс орны хөгжлийг хөдөлгөхөд чухал үүрэг гүйцэтгэж буй шинэ техник, технологийн талаар мэдлэг хомс байгаа явдал юм. Нэгэнт хэн нэгний ойлгохгүй байгаа асуудлыг нөгөө нэг нь зохицуулж чадахгүй учир олонх бодлого боловсруулагчид МХХТ-ийн бодлогыг тодорхойлж, боловсруулахаас жийрхэх явдал бишгүй тохиолдоно. Гэхдээ техник технологийн мэргэжлийн хүмүүс МХХТ-ийн бодлогыг тодорхойлох нь бас явцуу, учир нь тэдгээр мэргэжлийн хүмүүс өөрсдийн зохион бүтээсэн, хэрэглэгчдийн хэрэглэж буй технологийг бодлогын талаас нь тайлбарлаж, үр нөлөөг таниулж мэдэхгүй байх талтай.

Иймд доор нэрлэсэн албан хаагчид, ажилтнууд, мэргэжилтнүүдэд зориулан Төрийн удирдагч нарт МХХТ-ийн мэдлэгийг олгох Академийн цуврал модулийг НҮБ-ын Хөгжлийн төлөөх МХХТ-ийн АНДБ-ийн сургалтын төвөөс боловсруулан толилуулж байна. Үүнд:

1. МХХТ-ийн бодлого боловсруулах асуудал эрхэлсэн үндэсний болон орон нутгийн хэмжээний бодлого боловсруулагч нар
2. МХХТ-д суурилсан хэрэглээг хөгжүүлэх, хэрэгжүүлэх асуудал эрхэлсэн засгийн газрын албан тушаалтнууд,
3. Төслийн удирдлага, зохион байгуулалтанд МХХТ-ийн хэрэгслүүдийг ашиглах зорилгоор ажиллаж буй төрийн байгууллагуудын менежерүүд.

Цуврал модуль нь хөгжлийн зорилтуудыг хангахад МХХТ-ийг ашиглахтай холбогдуулан бодлогын болон технологийн аль аль талаас нь авч үзэх шаардлагатай асуудлуудыг таниулах зорилготой. Гол нь МХХТ-ийн техникийн авлага боловсруулах бус харин орчин үеийн тоон технологийн хөгжил дэвшилд гүйцэтгэх үүрэг, үүнтэй уялдуулан авч хэрэгжүүлэх бодлогын асуудлуудын талаар ойлголт өгөх явдал юм. Цуврал модулиар хүргэх сэдвүүдийг дэлхийн олон улс оронд явуулсан сургалтуудын эрэлт хэрэгцээнд хийсэн шинжилгээ, судалгааны үндсэн дээр тодорхойлж боловсруулсан.

Эдгээр цуврал модулийг бие дааж судалж болохын зэрэгцээ сургалтын курс семинар эсхүл хөтөлбөр хэлбэрээр ашиглаж болно. Цуврал бүр өөр өөрийн гэсэн онцлог сэдвүүдээс бүрдэх боловч харилцан уялдаатай асуудлуудыг хөндсөн бөгөөд модуль тус бүрт байгаа сэдвүүдийг нөгөө модулиудтай уялдуулан ярилцах, ойлгуулах аргаар ашиглаж болно. Цуврал модулийн урт хугацааны зорилго нь нэг багц сэдэв болж гэрчилгээ авах бололцоог уншигч, судлагч нарт олгоно.

Модуль тус бүрийн эхэнд тухайн модулийн зорилго, үр дүн буюу уншиж судалсны дараа нөхцөл байдлыг үнэлж дүгнэх асуултуудыг тусгасан болно. Мөн модуль тус бүр нь тухайн сэдвийг гүнзгийрүүлэн ойлгох боломж олгох судалгаа, жишээ, дасгалуудаас бүрдсэн бүлгүүдэд хуваагдана. Дасгалыг дангаар бие дааж болон багаар хамтран ажиллан гүйцэтгэж болно. Тухайн яригдаж буй сэдвийн талаарх нарийн өгөгдөл, мэдээллүүдийг зураг болон хүснэгтээр харуулсан. Нэмэлт дэлгэрэнгүй мэдээлэл авахад зориулан лавлах эх сурвалжууд болон интернэтийн хаягуудыг өгсөн болно.

Цуврал модулиудад тусгасан судалгаа, жишээнүүд нь өөр хоорондоо зөрчилтэй байж болох учир ХТМХХТ-ийг хэрэглэхэд олон талын асуудлууд гарч болзошгүй. Энэ нь улс орнууд МХХТ-ийн нөөц бололцоог хөгжлийн зорилтуудыг хангах хэрэгсэл болгон судалж буй энэ үед энэхүү шинээр үүсэн гарч буй мэдлэгийн салбарын үр өгөөж, нөгөө талаас тулгарч болох хүндрэл бэрхшээл юм.

Онлайн зайн сургалтын үед Академийн цуврал модулийг хэвлэмэл хэлбэрээр ашиглах ба Виртуал академи (AVA – <http://www.unapcict.org/academy>) нь сургагч багшийн хичээлийг дүрс бичлэгээр болон Power Point хэлбэрээр үзүүлж зохион байгуулна.

Үүний зэрэгцээ, Сургалтын төв (APCICT) нь МХХТ-ийн дадлага эзэмшигчид болон бодлого боловсруулагч нарын сургалт, туршлагыг бэхжүүлэх зорилгоор онлайн сургалтын цахим хуудас болох “e-Collaborative Hub for ICTD (e-Co Hub – <http://www.unapcict.org/ecohub>)” нээн ажиллуулж байна. Тус цахим хуудас нь хөгжлийн зорилтын төлөө МХХТ-ийг ашиглахад чиглэсэн төрөл бүрийн мэдээллийн эх сурвалжаар хангахын зэрэгцээ хамтран ажиллах, мэдлэг туршлага, солилцох чиглэлээр харилцан холбогдох боломж олгоно.

МОДУЛЬ 5

Интернэт нь төрийн бодлого, хүний хөгжлийн тогтвортой байдлын асуудлаар олон улсын болон улс орнуудын хүрээнд ихээхэн сорилтуудыг бий болгож буй билээ. Тиймээс Интернэтийн хэрэглээ, үйл ажиллагааг засаглах чиглэлээр олон улсын хэмжээний бодлого, үйл явцыг боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа үргэлжлэн явагдсаар байна. Ази, Номхон далайн бүсд дэлхийн хэмжээний Интернэт хэрэглэгчдийн дийлэнх хувь нь байдаг ч Интернэтийн бодлого боловсруулах үйл явцын хувьд бусдаас хавьгүй доогуур түвшинд байгаа юм. Энэхүү бүс нутагт Интернэтийн засаглалтай хамаарах хэд хэдэн асуудлууд, онцлог сорилтууд тулгараад буй билээ. Хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын Засгийн газар дэлхий нийтийн мэдээллийн сүлжээнд өөрийн дуу хоолойг хүргэхээр тэмүүлж буй л бол эдгээр асуудлуудыг ойлгох, шийдэхарга хэмжээ авах шаардлага үүсээд байгаа юм.

МОДУЛИЙН ЗОРИЛГО

Тус модуль нь дараах зорилгуудыг агуулсан болно. Үүнд:

1. Интернэтийн хэрэглээ, үйл ажиллагааг засаглах олон улсын бодлого, үйл явцыг боловсруулах үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, болон
2. Бүсийн хэмжээнд Интернэтийн засаглалтай хамаарах асуудлууд болон онцлог сорилтуудын талаар тоймлон өгүүлэх

СУРГАЛТААС ГАРАХ ҮР ДҮН

Тус модулийг судалж, танилцсанаар дараах мэдлэг, дадлыг эзэмшинэ. Үүнд:

1. Интернэтийн хэрэглээ, үйл ажиллагааг засаглах олон улсын бодлого, үйл явцыг боловсруулах чиглэлийн үйл ажиллагааны талаар тайлбарлах,
2. Хөгжиж буй орнуудын зүгээс Интернэтийн засаглалтай холбоотой шийдэх гол асуудлуудыг хэлэлцэх,
3. Өөрийн улс оронд Интернэтийн засаглалыг илүү үр дүнтэй явуулах анхны алхамуудыг тодорхойлох

Агуулга

Өмнөх үг	3
Удиртгал	5
Цуврал модулийн тухай	7
Модуль 5	9
Модулийн зорилго	9
Сургалтаас гарах үр дүн	9
Кэйс-судалгааны жагсаалт	11
Зургийн жагсаалт	11
Товчилсон үгсийн тайлбар	12
1. ИНТЕРНЭТИЙН ЗАСАГЛАЛ, хамрах ХҮРЭЭ	13
1.1 Танилцуулга	13
1.2 Интернэтийн түүх болон техникийн үндэслэл	13
2. ИНТЕРНЭТИЙН ОЛОН ТАЛТ болон олон САЛБАРЫН ЗАСАГЛАЛ	19
2.1 Тодорхойлолт	19
2.2 Зөвлөмжүүд	21
3. ИНТЕРНЭТИЙН ЗАСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТ 1- ИНТЕРНЭТ АШИГЛАЛТ	25
3.1 Зохицуулалтын арга зам	25
3.2 Санал болгож буй стратеги төлөвлөгөө	27
4. ИНТЕРНЭТИЙН ЗАСАГЛАЛЫН ЦАР ХҮРЭЭ 2- ИНТЕРНЭТИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ	35
4.1 Интернэт юугаараа онцлогтой вэ?	35
4.3 Интернэтийн зүй бус хэрэглээ	36
4.3 Хориг	39
5. ОФФЛАЙН хэрэглээг хамаарах АСУУДЛУУД	44
5.2 Цензур болон үг хэлэх эрх чөлөө	45
5.3 Нэр хүндэд халдах	46
5.4 Зохиогчийн эрх болон бусад оюуны өмчийн эрх	47
5.5 нууцлал	48
6. ХӨГЖЛИЙН ЦАР ХҮРЭЭ	49
6.1 Хөгжлийн төлөөх МХХТ	49
6.2 Хязгаарлалтууд болон саад тотгорууд	51
6.3 МХХТ-ийн хөгжлийн хэрэглээний программ	51
7. ИНТЕРНЭТИЙН ЗАСАГЛАЛ: ИРЭЭДҮЙГ ХАРАХУЙ	53
ТОЙМ	54
ХАВСРАЛТУУД	56
Нэмэлт материал	56
Сургагч багшид зориулсан зөвлөмж	57
Зохиогчийн тухай	59

КЭЙС-СУДАЛГААНЫ ЖАГСААЛТ

Электрон нотолгоог хүлээн зөвшөөрөх нь	29
Хууль бус контент: Дэлхий нийтийн зохицуулалт	30
I LoveYou вирус	31
Хууль бусаар хөгжим ашиглах	32
Хэрэглэгчдийн жил тутмын цэвэрлэгээ	37
Харилцаа холбоо болон Интернэтийн өртгийг чөлөөлөх нь	45

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Интернэт дээр вебсайт байрлуулах нь	18
Зураг 2.	Интернэтийн засаглалд оролцох олон талын болон салбаруудын оролцоо	21
Зураг 3.	Зохиогчийн эрхийн тэнцлийн хууль	57

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

APCICT	Хөгжлийн төлөөх МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төв (Asian and Pacific Training Centre for Information and Communication Technology for Development)
ccTLD	Улсын кодын дээд түвшний Домэйн (Country Code Top-Level Domain)
E3	Европын зөвлөл
НҮТ	Нийтлэг үйлчилгээний төв, Энэтхэг
DEC	Дижитал эквипмент корпораци
DNS	Домэйн нэрийн систем
ЭЗНХ	Ази, Номхон Далайн бүсийн эдийн засаг, нийгмийн Коммисс (Economic and Social Commission for Asia and the Pacific)
EX	Европын холбоо
FOSS	Free and Open Source Software- Төлбөргүй, нээлттэй эхийн програм хангамж
GPS	Байршил тогтоох систем
gTLD	Ерөнхий дээд түвшний Домэйн (Generic Top-Level Domain)
ICANN	Интернэтийн нэр, дугаар олголтын корпорац
ОУХХС	Олон улсын хэрэглэгчдийг хамгаалах сүлжээ
ИАГЗХ	Интернэтийн контентын зэрэглэлийн холбоо
МХХТ	Мэдээлэл, харилцаа холбооны технологи
ХТМХХТ	Хөгжлийн төлөөх Мэдээлэл, харилцаа холбооны технологи
IP	Интернэт протокол
IPv4	Интернэт протокол хувилбар 4
IPv6	Интернэт протокол хувилбар 6
ОУЦХБ	Олон улсын цахилгаан холбооны байгууллага
МХЗ	Мянганы хөгжлийн зорилтууд
ТХХТ	Төр хувийн хэвшлийн түншлэл
АДБҮХ	АНУ-ын дуу бичлэгийн үйлдвэрийн холбоо
БИР	Бүсийн Интернэт регистр
TCP/IP	Дамжуулах хяналтын протокол/ Интернэт протокол
TLD	Дээд түвшний Домэйн
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
АНУ	Америкын нэгдсэн улс
ИЗАХ	Интернэтийн засаглалын ажлын хэсэг

ТЭМДЭГЛЭГЭЭНҮҮД



Кейс судалгаа



Асуулт



Дасгал



Өөрийгөө шалгах нь

1. ИНТЕРНЭТИЙН ЗАСАГЛАЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү бүлэг нь Интернэтийн засаглалын товч түүх, нөхцөл байдлын талаар товч дурдаж, Интернэтийн засаглалын цар хүрээний тухай анхан шатны мэдлэг олгох зорилготой.

1.1 ТАНИЛЦУУЛГА

Интернэт хэмээн нэрлэгдэх энэхүү шинэ төрлийн МХХ-ний хэрэгслийг зохицуулах боломжгүй хэмээн олон хүн үздэг. Учир нь анхлан Интернэтийг хэрэглэж үзсэн хүн энэхүү сүлжээг цөмийн довтолгоо, бүслэлтийг тэсвэрлэх сүлжээ бий болгох цэргийн зориулалтаар зохион бүтээгдсэн, олон улсын хил хязгаараас үл хамаарах тул хянах, цензурдэх боломжгүй хэмээн гүнээ итгэсэн байдаг. Цензурдэх боломжгүй гэдэг нь Интернэтийн контентыг хянахад хүндрэлтэй, тиймээс хэрэглэгчдийг нь зохицуулах, хянах боломжгүй хэмээх утгыг агуулдаг.¹

Интернэт олон нийтэд нээлттэй болсоноос хойш 10 гаруй жил өнгөрч буй бөгөөд Интернэтийн талаарх энэхүү үзэл баримтлал нь зөвхөн домог төдий зүйл болохыг бид мэдрэн, Интернэтийг зохицуулж болно гэдгийг ойлгох түвшинд өнөөдөр хүрээд байна. Хэрэг дээрээ өндөр хөгжилтэй улсууд Интернэтийн хэрэглээнд илүү зохицуулалт сайтай байдаг бол хөгжиж буй орнуудын хувьд Интернэтийг засаглах чиглэлээр маш цөөн тооны журам дүрэмтэй, зарим тохиолдолд огт байдаггүй ажээ. Хөгжиж буй орнуудад журам заавар хомс байх нь Интернэтийг ашиглан, жишээ нь спам, скамыг ашиглан залилан мэхлэх үйл ажиллагаа явуулагч этгээдүүдэд таатай нөхцлийг бүрдүүлж байдаг.

Гэхдээ Интернэтийг зохицуулах чиглэлийн журам зааврын тоо хэмжээ нь чухал бус. Хэрэв тоо чухал байдаг байсан бол АНУ нь Интернэтийн хэрэглээний хувьд хамгийн сайн зохицуулалттай, харин Лаос зэрэг өнөөг хүртэл дэд бүтцийн хувьд ихээхэн асуудалтай байгаа улсын хувьд Интернэт хөгжин цэцэглэж байх ёстой юм. Хамгийн гол нь Интернэтийг зохицуулж, засаглаж буй дүрэм журам нь эрх зүйн болон техникийн асуудлуудын талаар сайн ойлголттой байж, олон улсын хэмжээнд хамтран ажиллах замаар хийгдэх ёстой билээ. Энэхүү модуль нь эдгээр асуудлуудыг тодруулах, Интернэтийн засаглал дахь олон улсын хэмжээний хамтын ажиллагааг хэрхэн бий болгох талаар өгүүлэх юм.

1.2 ИНТЕРНЭТИЙН ТҮҮХ БОЛОН ТЕХНИКИЙН ҮНДЭСЛЭЛ

Түүхэн болон техникийн хөгжил

Интернэт анхлан үүсэхдээ цөмийн дайралтыг тэсэн үлдэхүйц мэдээлэл харилцааны сүлжээ бий болгох бус харин физикчид тооцоолол маш ихээр шаарддаг асуудлуудыг шийдэхийн тулд компьютерүүдээ холбон мэдээлэл хуваалцаж байхын тулд үүссэн юм. Тухайн үеийн компьютерууд нь том орон зайг эзэлсэн, үнэтэй тоног төхөөрөмж байсан билээ². Компьютеруудыг холбох аргачлал болгож 1960-аад онд зохион бүтээгдсэн протоколыг ашигласан ба энэ нь сүлжээний технологиос хамааралгүй бие даасан байдалтай байжээ. Нэг байрлалаас мэдээ илгээхийн тулд заавал сайн тоног төхөөрөмж, технологи ашиглах ёстой байв. Харин тухайн протокол нь компьютерээс илгээж буй мэдээллийг багц өгөгдөл болгон илгээж, улмаар хүлээн авч буй компьютер нь үүнийг задлах боломжийг бий болгосон ажээ. Хэрэв илгээсэн мэдээллийг хүлээн аваагүй бол дахин илгээх шаардлага үүсдэг байв. Өгөгдөл дамжуулах энэхүү аргачлал нь тухайн сүлжээ нь “ухаалаг” сүлжээ байхыг тэр бүр шаарддаггүй байлаа. Хэрэгцээтэй гол зүйлс

1. Peng Hwa Ang, *Ordering Chaos: Regulating the Internet* (Singapore: Thomson, 2005).

2. Katie Hafner and Mathew Lyon, *Where Wizards Stay Up Late: The Origins of the Internet* (New York: Simon and Schuster, 1998).

нь гэвэл мэдээллийн хаашаа явахыг нь замчлагч руутер бөгөөд үүний тусламжаар мэдээлэл нь энэхүү “тэнэг сүлжээнд” өөрийн явах замыг олдог байжээ. Тухайн харилцан холбох протокол нь (Internetworking protocol) өгөдлийг олон төрлийн сүлжээгээр дамжуулахад илүү сайн байсан ч утсан харилцаанд хэрэглэж байсан протоколоос хавьгүй дээр байжээ.

Харилцан холбох протокол нь илүү давуу талтай болохыг 1970-аад оноос эхлэн мэдэрч телефон холбооны компаниуд нь өөрийн сүлжээгээ “ухаалаг” болгож эхэлжээ³. Хэдийгээр Олон улсын цахилгаан холбооны байгууллага буюу НҮБ-аас дэлхий нийтийн цахилгаан холбооны үйл ажиллагааг зохицуулах зорилгоор байгуулагдсан байгууллага нь зарим нэгэн протокол, стандартыг боловсруулан гаргасан ч харилцан холбох протокол нь телефон утасны компаниудын протокол болон цааш өргөжсөн байна.

Интернэтийн засаглалын түүх⁴

Технологийн ертөнцөд протокол, стандартууд нь ихээхэн чухал бөгөөд үүнийг хянаж байгаа этгээд бүхнийг хянаж, технологийн чиглэл хааш явахыг чиглүүлэх боломжтой. Интернэтийн хувьд өөр өөр сүлжээнүүдийг нэгтгэх зорилгод ашиглагдаж байсан протоколыг одоо дамжуулалтын хяналтын протокол (Transmission Control Protocol/Internet Protocol-TCP/IP) хэмээн нэрлэх болжээ. Винтон Герф болон Боб Канн нарын 1974 онд зохион бүтээсэн энэхүү харилцаа холбооны протокол нь сүлжээний үйл ажиллагаанд ихээхэн чухал байсан тул TCP/IP ашиглаж буй ямар ч сүлжээг Интернэт хэмээн нэрлэх боломжийг хангасан юм.

Энэхүү сургалтын модульд зориулан тухайн протоколын хамгийн сонирхолтой зарчим нь сүлжээгээр дамжиж буй харилцаа холбоонд явах нэгэн байдлаар шууд хяналт тавьдаггүй, харин мэдээлэл түгээж буй хаяг дээр нь л хяналт тавьдаг систем болохыг хэлэлцэх юм. Хаягжилтын гол зорилго нь хаягийн зөрүү гарах, давхцахаас сэргийлэх явдал билээ. Дэлхий нийтийн хаягийн системд сүлжээг заах зорилгоор дугаарыг ашигладаг. Зарим хүмүүс, байгууллагууд ижил хаягтай байхаас сэргийлэхийн тулд төвлөрсөн директор байх шаардлагатай байдаг. Тиймээс Калифорнийн их сургууль болон Өмнөд Калифорнийн их сургуулийн төгсөгч Жон Постел Мэдээллийн шинжлэх ухааны хүрээлэнгийн захирлаар ажиллаж байх үедээ “Экономист” сэтгүүлд дурдсанаар “Интернэтийн бурхан” хэмээн нэрлэгдэх болсон билээ. Учир нь тэрбээр дээр дурдсан асуудлыг шийдсэнээр Интернэт сүлжээ хөгжих эхлэлийг тавьсан билээ.

Сүлжээний тоо нэмэгдэх тусам нэг бүрийнх нь дугаарыг тогтоох нь илүү хүндрэлтэй болж иржээ. Тиймээс 1983 онд Постел болон Пол Мокапетрис нар дугааруудад нэр өгч эхэлсэн байна. Жишээ нь 64.233.161.18 хэмээн бичихийн оронд google.com хэмээн бичиж энэхүү хайлтын сайтад нэвтрэх болжээ. Энэ нь утасны дугаарын системд нэр өгөхтэй төстэй үйл явц байсан билээ. Үүнээс үүдэн Домэйн нэрийн систем хэмээх (Domain Name System - DNS) ойлголт анх гарчээ.

Домэйн нэрийн систем нь өөрөө мөн зарим талаар эрх зүйн асуудлуудыг үүсгэж байгаа бөгөөд үүнийг дараа дараагийн бүлгүүд дээр судлах болно. Одоогоор хамгийн гол нь тулгараад буй асуудлыг ойлгохын тулд Домэйн нэрийн системийн талаар ойлголт авах нь чухал юм⁵.

Домэйн нэрийн систем нь “модтой адил” систем бөгөөд сүлжээ болон компьютерүүдийн талаарх мэдээллийг зохион байгуулалтад оруулах систем юм. Энэ нь үндсэндээ шуудангийн хаяг бичихэд эхлэн хот, гудамжны хаяг дараа нь улсын нэрийг тавьдагтай адилаар дээд түвшний Домэйныг (Top level domain- TLD) төгсгөлд нь харин сүлжээний онцлог хаягийг эхэнд нь бичдэг тогтолцоо билээ. Тиймээс компьютер нь Интернэтийн

3. David S. Isenberg, “The Dawn of the Stupid Network,” ACM Networker 2.1 February/March (1998): 24-31, <http://www.isen.com/papers/Dawnstupid.html>.

4. Any book that touches on the history of the Internet would be a good resource. Two such book are Hafner and Lyon's Where Wizards Stay Up Late, and Jack Goldsmith and Tim Wu's Who Controls the Internet: Illusions of a Borderless World. A reliable online resource is The Internet Society's Histories of the Internet at <http://www.isoc.org/internet/history>.

5. See http://en.wikipedia.org/wiki/Domain_name_system for a more detailed account of the DNS.

хаягийг хайхдаа баруунаас нь зүүн тийш эхлэн хайх ба улмаар сервер болгоноос зүүн талын нэрийг хайх байдлаар явагдана.

1985 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжиж эхлэхдээ анхлан бдээд түвшний Домэйнтай байсан нь:

COM – арилжааны байгууллагууд
EDU – боловсролын байгууллагууд
NET – сүлжээний үйлчилгээ үзүүлэгчид
ORG – ашгийн бус байгууллагууд
MIL – АНУ-ын арми
GOV – АНУ-ын Засгийн газар⁶

Энэ үеэс хойш нэмэлтээр ерөнхий Домэйн TLDs (gTLDs) нэмэн оруулж хэрэглэх болсон юм⁷. Энэхүү модулийн зорилгод хамгийн хамааралтай нь тухайн улсын кодыг хэрэглэх явдал юм (TLDs буюу ccTLDs). Энэхүү код нь ISO 3166-1 alpha-2 two-letter хэмээх кодтой ижил төстэй⁸. АНУ ч гэсэн өөрийн 2 үсэгтэй ccTLD (US) кодтой байдаг. Гэхдээ АНУ нь анхлан Интернэтийг үүсгэсэн давуу талаа шиглан gTLD кодыг улсын кодгүйгээр ашигладаг бөгөөд ялангуяа COM хаяг дээр үүнийг АНУ-аас эсвэл өөр газраас авсан байж болдог.

ccTLDs кодтой байна гэдэг нь Домэйн нэрийн талаар шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой. Жишээ нь yahoo.fr Домэйн нь Франц улс дахь Домэйны администраторын журмаар зохицуулагдах юм. Францын шүүхээс Yahoo нь нацист үзлийг харуулсан бэлэг дурсгалын зүйлийг Францын хэрэглэгчдэд зориулсан вебсайтаар дамжуулан зарахыг хориглосон байдаг. Yahoo.fr хэмээх Домэйн нэр нь Францад бүртгэлтэй тул Францын шүүх нь энэхүү сайт дээр өөрийн шийдвэрээ хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм. Үүнтэй холбоотойгоор Yahoo нь Франц хэлтэй хэрэглэгч нарт зориулсан вебсайтаа fr.yahoo.com хэмээн нэрлэх болсжээ. Энэхүү хаягийг харахад шинэ вебсайт нь нь COM Домэйнтай бөгөөд Yahoo дээр Франц улсад зориулсан сервер дээр байрлаж байна гэсэн үг. Ингэснээр Yahoo нь Францын шүүхийг эсэргүүцэх боломжтой ч арилжааны үүднээс аваад үзвэл ингэх шаардлагагүй юм. Улмаар Yahoo нь өөрийн гадаад сайтуудаа бүгдийг нь дээрхийн адилаар өөрчилсөн, гэхдээ бүх хаяг нь COM Домэйнтай хэвээр байж, тухайн улсын хэрэглэгч нарт зориулсан хэвээр ч Домэйн нь COM учраас зохицуулалт хамааралгүй болгожээ.

Мөн хэлэлцэх шаардлагатай өөр нэгэн техникийн асуудал байгаа бөгөөд энэ нь язгуур сервертэй (root server) хамаарах юм. Компьютер нь хаяг хайж эхлэхдээ баруунаас нь эхлэн зүүн тийш дарааллаар байдаг. gTLD нь хаягийн баруун талд байх компьютер хамгийн түрүүн баруун талын хаягтай нийцэх хаягийг хайж эхэлнэ. Жишээ нь www.google.com хаягийг оруулахад компьютер эхлээд .com хаягийг хайна. Орчин үеийн DNS код нь шууд бус хамааралтай кодыг багтаах ба Интернэтийн бүх Домэйн цэг ('.') хэмээх тэмдэгтээр дуусаж байгаа нь суурь серверийн код юм. Ийм суурь байгууллага 12 байдаг бөгөөд тэдгээрийн суурь серверийн оператор хэмээн нэрлэх ба тэд А-М хүртэл дугаарлагдсан серверүүдийг ажиллуулдаг. А сервер нь мастер сервер бөгөөд В-М хүртэлх серверүүдтэй өдөрт хэд хэдэн удаа харилцан мэдээллийг дамжуулж байгааг баталгаажуулж байдаг. Практик дээр, мэдээллийн ихэнх нь дэлхий даяар тархан байрласан бусад серверүүд дээр байрладаг бөгөөд ингэснээр Интернэтийн урсгалыг бууруулан, нэвтрэх боломжийг түргэсгэдэг. Энэхүү бүхэл талбарыг Язгуу рбүс буюу зон⁹ хэмээн нэрлэдэг. Энэхүү язгуур зон нь Интернэтийн үйл ажиллагаанд ихээхэн чухал тул хакеруудаас нуусан сервер хүртэл байдаг бөгөөд эдгээрийг нууцлагдмал серверүүд хэмээн нэрлэдэг. Нууцлагдмал болон А мастер сервер нь АНУ-д байдаг.

6. See http://en.wikipedia.org/wiki/Generic_top-level_domain for a more detailed account of the TLD system.


7. For a definitive list, see <http://data.iana.org/TLD/tlds-alpha-by-domain.txt>. A more reader-friendly list is available at http://en.wikipedia.org/wiki/List_of_Internet_top-level_domains.

8. See http://en.wikipedia.org/wiki/ISO_3166-1_alpha-2 for more details about ISO 3166-1 alpha-2.

9. Wolfgang Kleinwächter, "De-Mystification of The Internet Root: Do We Need Governmental Oversight?" in Reforming Internet Governance, ed. William J. Drake (New York: UN ICT Task Force, 2005), 209-225, www.wgig.org/docs/book/WGIG_book.pdf.

Зураг 1. Интернэт дээр вебсайт байрлуулах нь

(Эх сурвалж: Дипло сан, <http://textus.diplomacy.edu/textusbin/env/scripts/Pool/GetBin.asp?IDPool=1175>)



Үүнээс үүдээд хэрвээ ямар нэгэн улс АНУ-тай дайны байдалтай байгаа тохиолдолд юу болох вэ гэдэг асуулт гарна. АНУ-ын Засгийн газар тухайн сөргөлдөгч улсыг язгуур бүсээс устгаж Интернэт дээрээс арчих уу?

Иракийн дайны өмнө IQ хэмээх Домэйн Интернэтээс алга болсон байлаа. IQ Домэйныг Саддам Хусейны хамтрагч нар бус Техас мужид амьдардаг Палестин гаралтай Арабчууд эрхлэн ажиллуулж байжээ. Тухайн Домэйныг ажиллуулагч ах дүү Элаши, тэдний бизнесийн хамтрагч нар 2002 онд Ливи, Сири улсууд руу компьютерийн тоног төхөөрөмж хууль бусаар экспортлосныхоо төлөө баригджээ. Үүнтэй давхцан эсвэл өөр бусад шалтгаанаар IQ Домэйн нэрийн системийг дайн эхлэхээс өмнө хаажээ. 2005 оны 7 дугаар сарын 28-ны өдөр НҮБ-ын томилсон Интернэтийн засаглалын ажлын хэсгийн гаргасан тайлан дээр үндэслэн НҮБ-ын албан ёсны хэлрүү тухайн тайланг орчуулахаас өмнө IQ Домэйн нэрийг Иракын Засгийн газарт олгосон билээ. Учир нь тухайн үед Иракийн Засгийн газар тогтвортой байсан ажээ.

Язгуур бүсийн хяналт нь Интернэтийн засаглалын гол асуудал хэмээн тооцогддог. Өөр бусад хамаарах асуудлууд ч мөн байсаар буй нь ойлгомжтой. Зарим улсууд IP /АйПи/ хаяг олгох асуудал дээр ихээхэн санаа зовдог. Интернэтийн хөгжилтэй уялдан АНУ-ын зарим сургуулиуд нь зарим жижиг улсуудаас илүү тооны IP хаяг эзэмшдэг байна. Гол асуудал нь IP хаяг түгээж байгаад бус харин хаягийн нөөц дуусахтай хамааралтай. Одоо ашиглагдаж буй Интернэт протокол хувилбар 4-ийн (IPv4) хүрээнд нийт 4,294,967,296 IP хаяг байдаг. Дэлхийн хүн ам энэхүү тооноос хавьгүй их тул хаяг дуусаж болох юм. Харин энэхүү асуудлыг илүү сайжруулсан Интернэт протокол хувилбар 6-гаар (IPv6) шийдэж болох ба энэ хувилбараар 340,282,366,920,938,463,374,607,432,768,211,456 (340 тэрбум их наяд их наяд) давтагдашгүй IP хаягтай болно¹⁰.

10. OECD, "Governments and business must tackle Internet address shortage together, says OECD," 15 May 2008, http://www.oecd.org/document/29/0,3343,en_2649_34223_40542045_1_1_1_1,00.html.

Интернэтийн засаглалын асуудал нь 2003 онд болсон Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд хэмжээний уулзалтаар илүү их анхаарал татах болсон билээ. Олон улс орнууд Интернэтийн засаглалын асуудлаар ажиллах хүсэлтэй байсан ч АНУ-ын зүгээс хөгжиж буй орнуудад энэхүү асуудлаар ажиллах чадавхи хангалтгүй хэмээн үзэж байжээ. Тиймээс НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү асуудлаар тайлан бэлтгэх Ажлын хэсгийг томилжээ. Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд хэмжээний уулзалтын зарчмуудад дурсанаар:

50. Олон улсын Интернэтийн засаглалын асуудлыг зохицуулалт бүхий арга замаар шийдэх ёстой. Бид НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаас нээлттэй, тэгш хамарсан байдлаар Ажлын хэсгийг томилон өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудын Засгийн газрууд, хувийн хэвшил, иргэний нийгмийн бүрэн хэмжээний, идэвхтэй оролцоотойгоор, хамаарах олон улсын байгууллагууд, форумыг хамруулан Интернэтийн засаглалын асуудлыг судлан 2005 гэхэд Интернэтийн засаглалын чиглэлээрх үйл ажиллагааны талаарх санал боловсруулахыг хүсэж байна¹¹. гэжээ.

Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд хэмжээний уулзалтаас 40 гишүүн бүхий хороо байгуулан баримт цуглуулах, Интернэтийн засаглалын талаар тодорхойлох, ямар үйл ажиллагаа эрхлэх, ямар асуудлууд байгаа зэргийг тогтоох үүрэг бүхий хороо байгуулжээ. Тус хороо нь өөрийн тайлангаа Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд хэмжээний уулзалтад тайлагнах ёстой юм.



Асуулт

Интернэтийн засаглал нь танай орны хувьд ямар ач холбогдолтой вэ?



Өөрийгөө шалгах нь

1. Интернэтийг ямар зорилгоор анх зохион бүтээсэн бэ?
2. Интернэтийн төв байхгүй гэж байнга яригддаг. Энэ үнэн үү?
3. Домэйн нэрийн систем нь Интернэтийг хэрхэн зохион байгуулдаг вэ?
4. IPv4 болон IPv6-ийн хооронд ямар ялгаа байдаг вэ?

11. World Summit on the Information Society, Declaration of Principles – Building the Information Society: A global challenge in the new Millennium (12 December 2003), <http://www.itu.int/wsis/docs/geneva/official/dop.html>.

2. ИНТЕРНЭТИЙН ОЛОН ТАЛТ БОЛОН ОЛОН САЛБАРЫН ЗАСАГЛАЛ

Энэхүү бүлэг нь Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд хэмжээний уулзалтаас гарсан тайлангийн талаар товч мэдээлэл өгөх, Интернэтийн засаглалын улс төрийн нөхцөл байдалын тухай болон Интернэтийн засаглалын форумын тухай мэдээлэл өгөх зорилготой.

Интернэтийн засаглалын эрх зүйн гол асуудал нь Интернэтийн үйл ажиллагааг бууруулах явдал биш юм. Тиймээс Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд хэмжээний уулзалт нь өөрийн үйл ажиллагааны голлох зарчмуудыг тодорхойлж, тухайлбал үүнд Интернэт нь урьдын адил тогтвортой, аюулгүй байх, үүний архитектур болон хөгжлийн стандарт нь нээлттэй, төвлөрөлгүй байх, тоо хэмжээ болон нэр, хаягийг бүрэн хэмжээгээр удирдах зэрэг зарчмуудыг багтаажээ.

2.1 ТОДОРХОЙЛОЛТ

Интернэтийн засаглалын тодорхойлолт нь анхлан зарим нэгэн эсэргүүцэлтэйгээр боловсрогдож эхэлжээ. Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд хэмжээний уулзалтад хэлсэн үгэндээ тухайн үеийн Олон улсын цахилгаан холбооны байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Ёошио Уцуми Интернэтийн засаглалыг тодорхойлсон товч тодорхойлолт гаргах хүсэлтэй байгаагаа мэдэгджээ. Тэрбээр:

Интернэт засаглалын улс төрийн үзэл баримтлалтай хамаарах олон тооны асуудлуудыг Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд хэмжээний уулзалтын өмнөх үе шатуудын хүрээнд өргөн хүрээнд хэлэлцэн, эхний үе шатны төгсгөлийн баримт бичгүүдэд гүйцэтгэх ажлууд болон баримтлах зарчмыг тогтоон оруулсан билээ. Засгийн газруудын хооронд өргөн хүрээний зөвшилцөл явагдсан тул энэ асуудлыг дахин дэлгэх шаардлагагүй юм. Тиймээс мэдээллийн чөлөөт урсгал, спамтай тэмцэх, сүлжээний аюулгүй байдал, бүс нутгийн язгуур серверүүд, хувийн нууцийг хамгаалах болон МХХТ-ийг буруугаар ашиглах зэрэг асуудлуудыг хөндөн ярих шаардлагагүй юм. Харин бид Интернэтийн эх үүсвэрийг Интернэтийн нэр, дугаар олголтын корпорацын (Internet Corporation for Assigned Names and Numbers) үйл ажиллагаагаар дамжуулан удирдах, тэр тусмаа дээд түвшний Домэйны асуудалд илүү анхаарал хандуулсанаар шийдэгдээгүй үлдсэн асуудлууд бүхий энэхүү салбарт зарим шийдэлд хүрч болох юм¹².

Ажлын хэсгээс энэхүү хязгаарлагдмал үзэл бодлыг хүлээн авалгүйгээр Интернэтийн засаглалын өргөн хүрээний тодорхойлолтыг боловсруулан гаргасан нь:

Интернэтийн засаглал гэдэг нь Засгийн газрууд, хувийн хэвшил болон иргэний нийгэм өөрийн өөрийн гүйцэтгэх үүргийн хүрээнд, нэгдмэл зарчим, хэм хэмжээ, заавар журам, шийдвэр гаргах үйл явц, хөтөлбөрийн дагуу Интернэтийн хэрэглээ болон хувьслыг зохицуулах үйл явцыг хэлнэ¹³. хэмээн тодорхойлжээ.

12. Yoshio, Utsumi, Welcome Speech (First Meeting of the Working Group on Internet Governance Geneva, Switzerland, 23-25 November 2004), <http://www.wgig.org/docs/Utsumi.pdf>.


13. WGIG, Report of the Working Group on Internet Governance (2005), 4, <http://www.wgig.org>.

Энэхүү тодорхойлолт нь бусад талуудаас санал болгож байсантай харьцуулбал товч бөгөөд тодорхой байлаа¹⁴. Тодорхойлолт нь хэд хэдэн байдлаар ач холбогдолтой юм. Нэгдүгээрт Интернэтийн засаглалыг зөвхөн Интернэтийн нэр, дугаар олголтын корпорацын үйл ажиллагаа хэмээн үздэг хязгаарлагдмал үзлийг үгүйсгэсэн. Хоёрдугаарт энэхүү тодорхойлолт нь спам, хувийн нууц, кибергэмт хэрэг, аюулгүй байдал, Интернэтийн хөгжил зэрэг асуудлуудыг хамарсан бөгөөд эдгээр асуудлууд нь олон улсын хэмжээний үйл ажиллагаанд тэр бүр сайн тусгагдаагүй байсан билээ. Гуравдугаарт энэхүү тодорхойлолтод хувийн хэвшил болон иргэний нийгмийг олон талын оролцоот хандлагад багтаан өгсөн нь өмнөх уулзалтуудаар нэгтгэн оруулж амжаагүй зүйлсийг хамруулсанд оршино. Учир нь Олон улсын цахилгаан холбооны байгууллага нь утасны компаниуд зэрэг олон улс оронд төртэй холбоотой байгууллагуудыг гишүүнчлэлдээ нэгтгэсэн байдаг. Тодорхойлолт нь мөн Интернэтийн засаглал бол зүгээр нэг хууль батлан гаргах явдал биш хэмээн үзсэн. Үүний хүрээнд Интернэтийн нийгэмлэгийн бий болгон, хөгжүүлж буй нийгмийн хэм хэмжээ, заавар журмыг мөн хамааруулсан. Ингэснээр Интернэтийн хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулсан иргэний нийгмийг хүлээн зөвшөөрсөн ажээ.

Тухайн тодорхойлолт нь Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд хэмжээний уулзалтын тунхагтай хослон Интернэтийн засаглал нь олон талын оролцоот үйл явц болох (Засгийн газар, хувийн хэвшил болон иргэний нийгмийг багтаасан), олон талын (олон улс орныг хамарсан), ил тод болон ардчилсан (олонхийн үзэл бодлыг хүндэтгэсэн) үйл явц болохыг тогтоожээ. Энэ нь Интернэтийн засаглалын үйл явц дахь ач холбогдлыг тод томруун харуулж буй билээ.

Зураг 2. Интернэтийн засаглал дахь олон талын төлөөлөл болон салбаруудын оролцоо

(Эх сурвалж: Дипло Сан, <http://textus.diplomacy.edu/textusbin/env/scripts/Pool/GetBin.asp?IDPool=1188>)



2.2 ЗӨВЛӨМЖҮҮД

Ажлын хэсгээс хэд хэдэн зөвлөмжийг гаргасан байна. Эхний зөвлөмж нь Интернэтэд хамаарах асуудлуудыг хэлэлцэх бүх оролцогч талуудын форумыг бий болгох талаар байв. Энэхүү форум нь зардал багатай бүтэц бүхий, шийдвэр гаргах эрх мэдэлгүй байх юм. Үүний гол зорилго нь оролцогч талууд тулгараад буй асуудлуудыг хэлэлцэн, туршлагаа хуваалцах боломжийг хангах явдал юм. Интернэтийн засаглалын хамгийн анхны форум нь 2006 онд Афин хотод болсон юм. Хоёрдугаар уулзалт нь Бразилын Рио Де Жанейро хотод зохион байгуулагдсан бол гуравдахь форум нь 2008 оны 12 дугаар сард Энэтхэгийн Хайдерабад хотод болжээ.

14. WGIG, Background Report (2005), <http://www.wgig.org>.

Ажлын хэсгийн хоёрдахь зөвлөмж нь Интернэтийн хяналттай холбоотой. Ажлын хэсгээс хяналтыг Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд уулзалтын зарчмуудын дагуу олон улсын хэлбэрт оруулах үүний хүрээнд хийгдэх хяналт нь олон талын оролцоот, ил тод, ардчилсан байдлаар явагдах шаардлагатайг онцолжээ. Ийм төрлийн хяналт нь Интернэтийн өдөр тутмын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох бус харин Ажлын хэсгийн санал болгож буйгаар АНУ-ын Засгийн газар өөрийн хяналт тавих эрхээ Интернэтийн нэр, дугаар олголтын корпорацд шилжүүлэх шаардлагатайг дурджээ.

Зөвлөмжид Интернэтийн нэр, дугаар олголтын корпорац нь Интернэттэй холбоо бүхий бусад байгууллагуудын дундаас хамгийн ил тод байгааг дурдсан ч тухайн корпорацтай холбоо бүхий асуудлуудыг ч мөн дурдсан байна. Юуны өмнө Интернэтийн нэр, дугаар олголтын корпорац нь gTLDs хэзээ шинээр үүсгэх талаар ямар нэгэн цаг хугацааны хуваарийг гарган мөрдөхгүй байна. Цагийн хуваарьтай байх нь gTLDs санал болгож буй байгууллагуудад ихээхэн ач холбогдолтой байх юм. Хоёрдугаарт корпорацын хамгийн ил тод бус хэсэг нь Засгийн газрын зөвлөлдөх хороо бөгөөд энэхүү хороонд улс орнуудын Засгийн газрууд өөрийн саналын уламжилдаг байна. Голлох асуудал нь Интернэтийн нэр, дугаар олголтын корпорац нь цорын ганц үйлчилгээ үзүүлэх эрх бүхий АНУ-ын компани байгаа бөгөөд энэхүү эрхийг тендерээр бус шууд олгосон явдал билээ. Хоёрдугаарт Интернэтийн нэр, дугаар олголтын корпорац нь АНУ-ын Худалдааны яамны доор Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг ажээ.

АНУ-ын Засгийн газраас Интернэтийн нэр, дугаар олголтын корпорац нь хяналтын үйл ажиллагааг үргэлжлүүлэх ёстой хэмээн үзэж буй хоёр шалтгааныг гарган ирсэн ба эдгээрт: (1) Интернэтийн тогтвортой болон аюулгүй байдлыг баталгаажуулах; болон (2) бусад улсуудын Засгийн газар Интернэтэд цензур тавихаас зайлсхийх¹⁵ хэмээх шалтгаанууд багтаж байна. Эдгээр шалтгааны аль аль нь маргаантай шалтгаан билээ. Эхний шалтгаанаас аваад үзвэл Интернэтийг ажиллуулах мэдлэг, чадвар АНУ-аас гадна байхгүй байна хэмээн ойлгогдож байна. Хоёрдугаар шалтгааныг аваад үзвэл XXX хэмээн Домэйн буюу садар самуун явдлыг сурталчилсан Домэйныг баталгаажуулсан, үүнийгээ больсон, улмаар үүнээс татгалзсантай холбон тайлбарлаж болно. Хэдийгээр энэ нь хувийн компани болох Интернэтийн нэр, дугаар олголтын корпорацын гаргасан шийдвэр байсан ч гэсэн татгалзахад АНУ-ын лобби бүлэг ихээхэн нөлөө үзүүлэн, АНУ-ын Засгийн газраас томилогдсон этгээд дэмжиж байжээ¹⁶.

Хэрвээ АНУ нь Интернэтийг дангаар эзэмшиж буй мэт авирлах тохиолдолд яах вэ? Энэ тохиолдолд АНУ давамгайлах байр суурьтай байгаа хоёр гол технологийг авч үзэж болох юм. Үүний нэг нь Байршил тогтоох систем (GPS) буюу иргэний хэрэгцээнд ашиглаж буй цэргийн систем юм. Европт үүний адил Галилео хэмээх системийг гаргасан нь АНУ-аас GPS системийг таслах тохиолдолд хэрэглэх систем юм¹⁷. АНУ давамгайлах байр суурьтай буй дараагийн нэгэн технологи нь Хамтарсан байлдааны онгоцны програм юм. Энэхүү 10 орныг хамарсан програмын нийт зардал нь 40 тэрбум гаруй ам доллар бөгөөд байлдааны онгоцыг удирдах зориулалт бүхий энэхүү програмын эх код нь АНУ-ын мэдэлд байдаг юм. Энэхүү кодыг тухайн хөтөлбөрт бусад оролцогч нарын дундаас хамгийн их хэмжээ болох 2.5 тэрбум ам долларын хувь нэмрээ оруулсан Англид ч өгөхөөс ч эхлээд татгалзаж байжээ. Английн Засгийн газар төслөөс гарахаа мэдэгдэн, төлөвлөж байсан 150 онгоц худалдан авахаа болихоо зарласны дараагаар АНУ-ын Засгийн газар Английн Засгийн газартай гэрээ байгуулан тухайн програмыг Англи улс авах боломжтой болжээ¹⁸.

Тоймлоод үзвэл зэрэгцээ орших паралель системтэй байх нь тухайн системүүдийг боловсруулах зардлыг нэмэгдүүлэх юм. GPS –ийн жишээн дээр аваад үзвэл Галилео систем нь АНУ-ын системээс илүү сайн нарийвчлалтай байгаа. Харин байлдааны нисэх онгоцны удирдлагын програмын хувьд АНУ-ын үйлдэл нь цаашид ийм ижил төрлийн програм зохиох үйл явцад түр завсарлага авах боломж олгох юм.

15. See, for example, the letter by US Congressman Edward Markey as chairman of the Subcommittee on Telecommunications and the Internet in "Markey, Committee Members Comment on Possible Changes to Internet Watchdog Agency," Office of Congressman Markey (6 May 2008), <http://markey.house.gov/index.php?option=content&task=view&id=3342&Itemid=125>.

16. Milton Mueller, "XXX Puzzle Pieces Start to Come Together: And the Picture is Ugly," CircleID, 17 August 2005, http://www.circleid.com/posts/xxx_puzzle_pieces_start_to_come_together_and_the_picture_is_ugly.

17. Directorate-General Energy and Transportation, "Galileo FAQ," http://ec.europa.eu/dgs/energy_transport/galileo/faq/index_en.htm.

18. BBC news.http://news.bbc.co.uk/2/hi/uk_news/politics/6173143.stm.

Ажлын хэсгийн гаргасан гуравдахь зөвлөмж нь Интернэтийн засаглалтай хамаарах олон төрлийн байгууллагууд, агентлагуудын хамтын ажиллагааг сайжруулах талаар байжээ. Засгийн газар хоорондын байгууллагуудын тоонд ОУЦХБ Дэлхийн оюуны өмчийн байгууллага, ЮНЕСКО зэрэг байгууллагууд багтаж байна. Интернэтийн байгууллагуудын тоонд Интернэтийн нэр, дугаар олголтын корпорац, Интернэтийн нийгэмлэг, Интернэтийн инженерингийн ажлын хэсэг, Дэлхийн вебийн консорциум болон Бүсийн Интернэтийн бүртгэгч байгууллага (RIRs) багтдаг. Ажлын хэсгийн зөвлөмжөөр ОУЦХБ-аас гадна Интернэтийн засаглалтай холбоотой өөр олон тооны байгууллагууд байгааг дурджээ. Товчхон хэлбэл ОУЦХБ нь Интернэтийн засаглалын асуудлаарх цорын ганц эрх бүхий байгууллага гэдэг нь бүрэн баталгаажаагүй юм.

Ажлын хэсгээс гаргасан дөрөвдэх зөвлөмжид бодлогын хүрээнд бүс нутгийн болон үндэсний хэмжээнд хамтран ажиллах шаардлагатайг дурджээ. Энэхүү зөвлөмж нь ccTLDs болон Засгийн газруудын хооронд илүү нягт хамтран ажиллаж “Интернэтэд ээлтэй бодлого” гаргахын чухлыг дурдсан байна. Мөн энэхүү зөвлөмжөөр Интернэтийн удирдах хороог байгуулан үндэсний хэмжээний Интернэтийн засаглалын асуудлыг хариуцуулах хэрэгтэйг мөн заажээ. Тодруулан авч үзвэл энэхүү хороо нь доорх асуудлуудыг хариуцах ажээ. Үүнд:

- Язгуур бүсийн файлуудыг удирдах, Домэйн нэрийн системийн суурь серверүүдийг удирдах
- IP хаягжилт
- Харилцан холбогдох зардал, үнэ
- Интернэтийн тогтвортой байдал, аюулгүй байдал болон кибер гэмт хэрэг
- Спамын асуудал
- Үзэл бодлоо илэрхийлэх эрх
- Дэлхий нийтийн бодлого боловсруулахад бүтээлчээр оролцох
- Мэдээллийн хамгаалалт болон хувийн нууцийн эрх
- Хэрэглэгчдийн эрх ашиг
- Олон хэлээр ажиллах нөхцөл

Эдгээр асуудлуудыг дараах 4 гол бүлэгт хуваасан баяа. Үүнд:

Биет дэд бүтэц - Энэхүү бүлэг нь улс төрийн асуудал бүхий буюу жишээ нь Интернэтийн нэр, дугаар олголтын корпорацтай хамаарах асуудал, Домэйн нэрийн болон IP хаягн асуудал, язгуур зоны сервер зэргийг хамруулсаны зэрэгцээ санхүүжилт шаардагдах асуудлуудыг мөн хамруулжээ.

Интернэтийн хэрэглээ болон хүчирхийлэл - Энэ хэсэгт спам, сүлжээний аюулгүй байдал кибер гэмт хэрэг зэрэг асуудлыг хамруулсан байна. Эдгээр асуудлуудыг шийдэх нь сүлжээг буруугаар ашиглах явдлыг бууруулан, хэрэглээг нэмэгдүүлэх юм.

Интернэтийн талаарх илүү үр нөлөө бүхий асуудлууд - Интернэтэд нөлөөлөх бодлого нь зөвхөн Интернэт бус хавьгүй илүү өргөн цар хүрээнд нөлөөлж болно. Үүний тодорхой жишээнд өрсөлдөөний бодлого, цахим худалдаа болон оюуны өмчийн эрх зэрэг хамаарна.

Интернэтийн хөгжлийн хэсэг - Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд уулзалтаас гаргасан “хөгжил нь хамгийн гол хөдөлгөгч хүч болно” гэсэн үзэл баримтлалыг харгалзан Интернэтийн засаглалын талаарх хэлэлцүүлгийн явцаас үзвэл хөгжлийн асуудал нь олон чиглэлийг хамаарч байна. Дижитал нэгдлийн санг МХХТ-ыг хөгжлийн зорилгод ашиглахын тулд эхлүүлсэн байна. Энэхүү агуулгаараа хөгжил гэдгийг МХЗ-уудтай холбон үзэж болно.

Эдгээр дөрвөн ангиллыг энэхүү модулийн дараа дараагийн хэсгүүд дээр судлах болно.



Дасгал

1. Танай оронд баримталж буй Интернэттэй холбоотой бодлогын жагсаалтыг гарга.
2. Энэхүү бодлого нь танай улсыг хэрхэн хөгжүүлсэн талаар эрэгцүүл.

Хөгжиж буй орнууд нь Интернэтийн засаглалтай холбоотой хоёр гол асуудалтай тулгардаг ба үүнд (1) Интернэтийн засаглалд хэрхэн үр дүнтэйгээр оролцох; болон (2) энэхүү асуудлыг шийдэх чадавхийг хэрхэн бэхжүүлэх гэсэн асуудлууд байдаг.

Тунисд болсон Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд уулзалт нь Ажлын хэсгийн гаргасан тайланд дурдсан дагуу Интернэтийн засаглалын асуудлыг улс орнуудын Засгийн газруудад хамруулан тэд өөрсдийн ccTLDs дээр тодорхой эрх эдлэхээр зохицуулсан байна.

Дүгнэлт

Ажлын хэсгийн тайлан нь Интернэтийн засаглалтай холбоотой голлох асуудлыг хөндсөн чухал баримт бичиг билээ. Энэ нь мөн Интернэтийн засаглалын үйл явцад загвар болдог. Тайланд Засгийн газар, хувийн хэвшил болон иргэний нийгмийг Интернэтийн засаглалын гол оролцогч талууд болохыг дурдсан. Ажлын хэсгийн үйл явц нь өөрөө ил тод нээлттэй байдлын загвар болсон билээ. Гэхдээ ажлын хэсгийн тайлан нь үйл ажиллагааны замын зураг бус, төлөвлөгөө ч бус юм.



Өөрийгөө шалгах нь

1. Ажлын хэсгээс Интернэтийн засаглалын тодорхойлолтыг хэрхэн гаргасан бэ? Үүний ач холбогдол юу байсан бэ?
2. Ажлын хэсгээс ямар гол зөвлөмжүүдийг гаргасан вэ?
3. Ажлын хэсгийн тайлангаас суралцаж болох Интернэтийн засаглалтай холбоотой ямар сургамжууд байна вэ?

3. ИНТЕРНЭТИЙН ЗАСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

1- ИНТЕРНЭТ АШИГЛАЛТ

Энэхүү бүлэг нь Интернэтийн зохицуулалтын төрөл, хэлбэрийн талаар судлах зорилготой.

Тухайн асуудлыг мэдэж байгаа бол одоо хэрхэн зөв бодлого гарган хэрэгжүүлэх вэ? Интернэтийг зохицуулах боломжтой юу?

Хэрэг дээрээ зарим дүрэм журмыг Интернэтийг зохицуулах зорилгоор гарган хэрэглээг нэмэгдүүлэх боломжтой.

3.1 ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА ЗАМ

Зохицуулалтын дараах 4 төрөл байна. Үүнд:

- Хууль – төр засгаас болон хувийн хэвшлээс хориг тавих, холбогдох журмыг сахиулах, түүний дотор засгийн газрыг төлөөлүүлсэн тохиолдолд чөлөөтэй байлгах зэргээр зохицуулах;
- Нийгмийн хэм хэмжээ–Хүлээлт, дэмжлэг болон сэтгэл зүйгээр дамжуулан зохицуулах;
- Зах зээлийн механизм–Ихэвчлэн үнэ болон хүртээмжийн асуудлын хүрээнд зохицуулах; болон
- Архитектур–Ямар технологийг зөвшөөрөх болон хориглох вэ¹⁹.

Архитектур

Архитектур хэмээх хэллэг нь зарим үйлдлийг дэмжих болон хориглох технологийн дизайныг хэлж буй. Жишээ нь автомашин хурд хэтрүүлэхийг хориглохын тулд илүү олон тооны замын цагдаа ажиллуулах болон хурд сааруулагч суурилуулж болно. Сингапурт орон сууцны хорооллын зам дээр тусгай саад үүсгэсэн байдаг ба ингэснээр жолооч нар хурдаа бууруулдаг байна. Үүний нэгэн адил дуу, видеог хуулбарлахыг хориглох зорилгоор зарим саад болон хамгаалалтыг хийдэг.

Интернэтийн тухайд гэвэл зарим хүмүүс Интернэтийн дизайн нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг бүрэн хангасан хэмээн үздэг. Тийм учраас контентийг зохицуулах ямар нэгэн оролдлого хийхэд ихээхэн хүндрэлтэй тулгардаг. Өмнөд Солонгосд хакеруудыг болон Интернэтээр довтолгоо хийгч нарыг тогтоон, барихаас өмнө аюулгүй байдлын алба нь тэдгээрийн хуурамч сүлжээнд нэвтрүүлэх занга буюу зөгийн торыг бэлддэг байна.

Зах зээлийн механизм

Зохицуулалтын энэхүү аргачлал нь бараа, үйлчилгээний үнэ болон хүртээмжтэй холбоотой. Зах зээлийн механизмыг ашиглаж буй зохицуулалт нь шударгаар өрсөлдөх, гэрээний тодорхой нөхцлүүд болон зах зээл дээрх өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зэргээр илэрдэг. Хамгийн гол нь худалдах, худалдан авах түвшинг баримталдаг байна.

19. Lawrence Lessig, Code 2.0 (New York: Basic Books, 2007)

Интернэт дээр хувийн мэдээллийн худалдах буюу ямар нэгэн агуулга хүлээн авах, уншихын тулд имэйл хаягаа өгөх зэрэг нь зах зээлийн механизмыг ашиглаж буй нэгэн жишээ билээ. Үүний гол санаа нь хэн нэгэн хүн өөрийн хувийн мэдээллийн ямар нэгэн контентоос илүүтэйгээр үнэлэх тул өөрийн имэйл хаягийг тийм амархан өгөхгүйд оршино. АНУ-д Trust-e зэрэг хувийн компаниуд хэрэглэгчдийн хувийн мэдээллийг хамгаалах үйлчилгээ үзүүлдэг. Үүний эсрэгээр ЕХ-ны үзэж байгаагаар хувийн мэдээлэл нь зөвхөн хувь хүн болон компанийн хоорондын зөвшилцлөөр бус харин хуулиар зохицуулагдах ёстой хэмээн үздэг байна.

Нийгмийн хэм хэмжээ

Нийгмийн хэм хэмжээг зохицуулах механизм болгон ашиглах нь нийгмийн дарамт шахалт хувь хүний зан төлөвт нөлөөлөх явц юм. Netiquette буюу сүлжээний ёс зүй нь нийгмийн хэм хэмжээг зохицуулалтар ашиглахын нэг жишээ байж болно. Netiquette-ийн дагуу форумд оруулж буй постууд тухайн сэдэвтэй хамааралтай байх ёстойгоос гадна хэн нэгэн хүн баярлаж талархаснаа илэрхийлсэн тохиолдолд дахин хариу өгөх шаардлагагүй байдаг.

Нийгмийн хэм хэмжээг ашиглах нь хялбар бөгөөд ялангуяа нийгмийн бүлгүүд өөрсдөө мониторинг хийх, хэрэгжүүлэх агентлаг байдлаар ажиллах боломжтой. Хэм хэмжээг зөрчсөн бол нийгмийн бүлгээс гаргах байдлаар хэрэгжиж болно. Ийм төрлийн шийтгэл нь нийгмийн бүлэгт харьяалагдах нь чухал тохиолдолд үр дүнтэй байж болно.

Хууль, чөлөөт зохицуулалт

Үндсэндээ хуулийг парламентаас өөрийн бодлогын хүрээнд гаргадаг. Ерөнхийдөө технологи зэрэг нөхцөл байдал хурдтай өөрчлөгдөж буй үед хууль батлан гаргахдаа анхааралтай байх хэрэгтэй. Энэ тохиолдолд түрүүлж хөдлөх нь сул талтай байж болно. Жишээ нь Юта мужийн цахим гарын үсгийн хууль нь дэлхийн хэмжээнд бараг анхных байсан ч шинээр технологи хурдтай гарч буйгаас хамааран маш хурдан хугацаанд хуучирсан түүхтэй. Сингапур болон АНУ нь сүлжээний үйл ажиллагааг дархлаажуулах чиглэлээр анхны хуулиудыг (Сингапурын жишээн дээр) болон бусад дагалдах хуулиудыг (АНУ-ын жишээн дээр) гаргасан ч удалгүй бусад улсууд тэдний хуулийг аван сайжруулан илүү үр дүнтэй хууль болгон гаргаж байжээ.

Үүнд хамаарах хамгийн сайн зөвлөгөө бол хууль нь технологийг удирдан, чиглүүлэхгүй тул гаргахаасаа өмнө олон тооны оролцогч талуудыг хамруулан зөвлөлдөх хэрэгтэй. Интернэт нь өөрийн хөгжлийн анхны шатандаа яваа гэдгийг анхаарч байх нь зүйтэй юм.

Чөлөөт зохицуулалт

Интернэтийн салбарт чөлөөт зохицуулалтыг хууль батлах, хэрэгжүүлэх үйл явцад илүү уян хатан байдлыг ханган өгөх арга зам болох талаар ихээхэн дурдах болжээ. Үндсэндээ чөлөөт зохицуулалт гэдэг нь анхлан тухайн салбар нь өөрөө салбараа зохицуулах гэсэн агуулгатай байсан ба ямар нэг компани болон хувь хүн өөрийгөө зохицуулах хэмээх санааг агуулаагүй байжээ. Практик дээр чөлөөт зохицуулалт хийсэн ч шийтгэл ноогдуулах хамгийн дээд эрх мэдлийг Засгийн газар эдэлдэг. Тиймээс Засгийн газар нь тухайн салбар өөрийгөө зохицуулах үйл явцыг тэргүүлэх хэрэгтэй гэсэн эрхийг олгох ёстой. Ихэнх өндөр хөгжилтэй орнуудад зар сурталчилгаа нь чөлөөт зохицуулалтын нэг хэлбэр болдог. Салбарын гаргасан шийдвэрийг эсэргүүцэн, үл тоомсорлогч нарын хувьд Засгийн газраас арга хэмжээ аван шийтгэл ноогдуулж болно.

Гэхдээ чөлөөт зохицуулалтыг бий болгохын тулд ихээхэн идэвхтэй хувийн хэвшил шаардлагатай. Зар сурталчилгааны салбарт Засгийн газар зөвшөөрөл олгодог бол

энэ нь үйл явцыг удаашруулан, бүтээлч байдалд саад учруулж болно. Интернэтийн салбар нь өөрийн зохицуулалтад тийм ч эерэг ханддаггүй. Зарим салбарынхан чөлөөт зохицуулалт нь тухайн салбарын төрийн хийх ажлыг өмнөөс нь хийж байна хэмээн гомдол гаргах тохиолдол байдаг.



Асуултууд

Зохицуулалтын 4 аргачлал танай оронд ямар хэмжээнд хэрэгждэг вэ? Танай улсад аль аргачлал нь илүү үр дүнтэй байх вэ? Яагаад? Танай улсад аль аргачлал нь үр дүнгүй байх вэ? Яагаад?

3.2 САНАЛ БОЛГОЖ БУЙ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Интернэтийн засаглалын тодорхойлолт нь агуулгын хувьд өргөн хүрээтэй тул бодлого боловсруулахад доорх бүтцийг урт хугацааны стратеги төлөвлөгөө болгон ашиглаж болно. Урт хугацааны стратеги төлөвлөгөө нь хэрэгжүүлэх ажлууд болон цаг хугацааг заадаг. Стратеги төлөвлөгөө нь ихээхэн үр дүнтэй бөгөөд үүнийг бодит үйл ажиллагаан дээр туршин шалгасан байдаг²⁰.

1996 онд анх замын зураг боловсруулахад олон улс орнууд электрон нотолгоог зохицуулах суурь журамгүй байсан билээ. Өнөөдөр харин суурь журамгүй улсуудын тоо маш цөөхөн болсон ажээ. Гэхдээ энэхүү бүтцийг өнөөдөр ч хэрэглэж болох ба энэ нь Интернэттэй холбоотой журам заавар болон бодлогыг сайжруулахад хэрэглэгддэг.

Ач холбогдлоор нь (өндөр ач холбогдолтойгоос буурах дарааллаар) ангилсан анхаарал хандуулах асуудлын тоонд:

1. Нэвтрэх ба үйлчилгээгээр хангах
2. Цахим худалдаа
3. Контентын зохицуулалт
4. Аюулгүй байдал
5. Оюуны өмчийн эрх
6. Хувийн нууц

Нэвтрэх эрх болон зардлын асуудалд хандан ажилласнаар Интернэтийг илүү өргөн хүрээнд түгээж болно. Хүртээмжтэй холбоотойгоор онлайн болон оффлайн нөхцлийн талаар зураглал гаргах боломжтой. Жишээ нь хэн нэгэн этгээд Интернэт ашиглан банкны луйвар хийвэл тухайн этгээдийг онлайн нотолгоон дээр үндэслэн шийтгэх заавар, журам байгаа юу? Оффлайн нөхцөлд үйлчилдэг хуулиудыг онлайн гэмт хэрэгт хамааруулах байдлаар асуудлыг шийдэж болно. Контентын зохицуулалт болон аюулгүй байдлын асуудлууд нь Интернэтийг ашиглан юу хийж чадах болон Интернэтгүйгээр оффлайн байдлаар юу хийж болох харьцаан дээр суурилна. Олон улс орон Интернэтийн контентыг хянах үйл явцдаа амжилт олоогүй бөгөөд харин залуучуудыг хамгаалах буюу доор 12 дээр дурдсанаас бусад дээр амжилт гаргаагүй билээ. Контентын зохицуулалт болон аюулгүй байдлын талаар шийдвэртэй алхам хийх шаардлага байгаа бөгөөд учир нь гэрийн компьютерээсээ садар самуун материал үзэх, эсвэл хэн нэгэн хакердсанаар мэдээллийг нь авч болон нөхцөлд байхаас зайлсхийх хэрэглэгчид байгаа. Оюуны өмчийн эрх болон хувийн нууцлалыг хадгалах нь Интернэтийн хэрэглээ нэмэгдэх тусам илүү их ач холбогдолтой болно.

20. Анг (2005)-ыг үзнэ үү.

Нэвтрэх эрх болон үйлчилгээгээр хангах

Энэхүү асуудлын хүрээнд анхаарах асуудлууд нь Интернэтийг хэрэглэх хямд боломжуудыг бий болгохтой холбоотой. Эдгээр асуудлын тоонд:

- Сүлжээнд холбогдсон орчинд техникийн стандартыг хэрхэн удирдах.
- Компьютерийн систем болон сүлжээний харилцаа холболт болон харилцан ажиллах боломжийг хэрхэн баталгаажуулах.
- Мэдээллийн үйлчилгээний үнэ болон үйлчилгээний чанарыг хэрхэн зохицуулах.
- Нэвтрэх эрх болон үйлчилгээ үзүүлэгч нарын хариуцлага, үүргийг тодорхой болгох жишээ нь тэднийг гуравдагч талын бий болгосон агуулгыг хариуцахаас хамгаалах зэрэг оржээ.

Дархлаажилтын асуудал нь ихээхэн чухал бөгөөд учир нь энэнгүйгээр э-худалдаа бүрэн хэмжээгээр явагдах боломжгүй болно.

Асуултууд



Олон улс оронд бусдын нэр төрд халдахаас хамгаалах тухай хууль тогтоомжинд хэн нэгэн хүнийг худлаа мэдээллээр гүтгэж хохирол учруулсан тохиолдолд тухайн хүнийг хохиролгүй болгох ёстой байдаг. Зарим улсуудад хохирлын хэмжээг тухайн худал мэдээллийг зориудаар тараасан уу үгүй юу гэдгээс хамааруулан тогтоодог. Харин зарим улсуудад үүнийг зориудаар үйлдсэн эсэх нь хамаагүй байдаг. Танай улсад хуулиар ямар хэмжээнд (а) номын тоймын талаар сайт, (б) зочид буудлын тоймын тухай сайт, болон (в) дуудлага худалдаангы сайтаар дамжуулан буруу мэдээлэл түгээхэд хэр хэмжээнд арга хэмжээ авдаг вэ? Энэ тохиолдолд Интернэт үйлчилгээ үзүүлэгч худлаа мэдээллийг түгээсэн хэмээн хариуцлага хүлээдэг үү?

Цахим арилжаа

Арилжааны үүднээс аваад үзвэл цахим арилжаа нь олон давуу талуудтай. Цахим арилжааны бизнес эхлүүлж буй компани нь өөрийн 24 цагийн дэлгүүртэй болсоноор дундын зуучлагч нараас татгалзан шинэ зах зээлийг бий болгодог. Цахим арилжаа нь үйл ажиллагааг автоматжуулдаг тул бизнесийг илүү үр дүнтэй болгодог.

Цахим арилжаа нь гэхдээ бүх бизнест зориулагдаагүй. Тавилга зэрэг үнэтэй зүйлсийг зардаг бизнесийн хувьд цахим арилжаа нь амжилтгүй болдог бөгөөд учир нь хэрэглэгчид өөрсдөө туршин, шалган үзэж байж бараагаа авах сонирхол ихтэй байдаг. Түүнчлэн зарим улсад дэлгүүр хэсэг нь чөлөөт цагаа өнгөрөөх нэг хэлбэр болдог тул цахим худалдаанаас татгалздаг.

Цахим арилжааны асуудалд хандахдаа үүнд Интернэтийн хэрэглээнд сөргөөр нөлөөлж болох олон асуудалд дагалдан гардаг болохыг санах нь зүйтэй. Энэ хүрээнд доорх зүйлс дээр анхаарах ёстой:

- Цахим орчинг хууль ёсоор баталгаажуулах
- Цахим нотолгоог хүлээн зөвшөөрөх
- Цахим шилжүүлгийг зөвшөөрөх
- Цахим гарын үсэг болон цахим гэрчилгээг хүлээн зөвшөөрөх
- Олон талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгон, маргаан таслах механизмыг бий болгох
- Цахим төлбөрийн механизм болон тэдгээрийн хэрэглээг дэмжих
- Цахим худалдаанд хууль ёсийг сахиулах цагдаагийн үүргийг өндөрсгөн, тэднийг чадавхжуулах
- Цахим худалдааны татварын асуудлыг тодорхой болгох

Үүний тулд цахим арилжааны эсвэл цахим шилжүүлгийн хуулийг батлан гаргах шаардлагатай болно. Ийм төрлийн хууль нь цахим арилжааны орчинг бэлтгэж өгөх юм.



Электрон нотолгоог хүлээн зөвшөөрөх нь

Олон оронд 1990-ээд оны дунд үеээс Интернэтийн хэрэглээ олон нийтэд түгэн тархаж эхэлсэнтэй холбоотойгоор электрон нотолгооны олон хэлбэрийг хүлээн зөвшөөрөх шаардлага гарч ирсэн юм. Жишээ нь цахим гарын үсэг шинээр гарч ирэхэд нотолгоотой холбоотой журам заавруудад нэмэлт өөрчлөлт хийх шаардлага гарч байв. Сингапурт Цахим шилжүүлгийн хуулинд 1996 онд нэмэлт өөрчлөлт оруулж байжээ. Энэтхэгт 2000 онд Мэдээллийн технологийн хуулийг өөрчилж байжээ. Товчхон хэлэхэд онлайн ертөнцөд болж буй үйл явцад нийцүүлэн оффлайн хэрэглээнд хэрэглэдэг хуулийг өөрчлөх нь шинээр үүсэн гарч буй шаардлага билээ.



Дасгал

Танай оронд цахим худалдааг бий болгох, сайжруулах журам заавар, зохицуулалт ямар байгаа вэ? Хэрэв ийм зохицуулалт байхгүй бол танай оронд цахим худалдааг бий болгох, сайжруулах ямар зохицуулалт шаардлагатайг эрэгцүүлэн бод.

Контентын зохицуулалт

Зарим хэрэглэгч Интернэт ашиглахгүй байгаа шалтгаанаа түүнд буй зарим төрлийн контенттой холбон тайлбарладаг. Гэхдээ тэдэнд үл тохирох контент гэж юу вэ гэдэг нь хүн хүнээсээ шалтгаалдаг. Энэхүү асуудлыг шийдэх нь сэргэлдөгч ашиг сонирхлын тэнцлийг олно гэсэн үг юм. Ямар нэгэн филтергүй байхын хамгийн гол давуу тал нь агуулга хязгааргүй байх явдал билээ. Заримдаа филтер нь хэт их хаалт хийдэг учир энгийн агуулга хүртэл үүнд өртөх магадлалтай байдаг.

Контентын зохицуулалтын хувьд доорх асуудлуудад анхаарах шаардлагатай:

- Интернэт дээр буй зохисгүй контентыг хэрхэн хязгаарлах, блоклох, ялангуяа хүүхдүүдийн сайн сайхны тулд үүнийг хэрхэн хийх
- Үндэсний ашиг сонирхлыг гадаадын зохисгүй контент бүхий материалаас хэрхэн хамгаалах.
- Мэдээллийн агуулгад байгаа сэргэлдөөнт соёлын үнэт зүйлсийг хэрхэн нэгтгэх.



Хууль бус контент: Дэлхий нийтийн зохицуулалт

Соёлын ялгаанаас хамааран зохисгүй, зөвшөөрөгдөхгүй агуулгын хувьд дэлхий нийтээр нэгдсэн зөвшилцөлд хүрэх боломжгүй байдаг. Гэхдээ ямар агуулга хууль бус вэ гэдэг дээр ерөнхий зөвшилцөлд хүрдэг зүйлс байдагийн тоонд хүүхдийн садар самуун кино зэрэг багтдаг.

Хууль сахиулах байгууллагуудын зохицуулалтын хүрээнд хүүхдийн порнографыг хянах үйл ажиллагаа багтдаг. Хууль сахиулах байгууллагууд энэ талаар хамтран ажиллаж, цэвэрлэгээ хийдэг билээ. 1990 оны сүүл үед Интернэтэд буй ихэнх материалыг оффлайн нөхцлөөс хуулбарлан оруулсан байдаг байсан бол Интернэт хөгжихийн хэрээр вебкамераар шууд дамжуулах байдал ч мөн нэмэгджээ. Ийм төрлийн хэрэглээг зогсоохын тулд цагдаагийн байгууллага хүүхдийн хүчирхийлэл бүхий зураг татан авч буй этгээдүүдтэй тэмцэх болжээ. Үүнтэй холбоотой хэдэн хэдэн тусгай ажиллагааг 1998 болон 1999 онуудад явуулан олон оронд олон зуун этгээдийг баривчилсан байна.

Илүү тодорхой мэдээллийг Ажлын хэсгийн тайлангийн (2005), хуудас 34 (мөр 141) дээрээс үзнэ үү. <http://www.wgig.org>.

Аюулгүй байдал

Аюулгүй байдлын асуудал нь Интернэтийн вирус, worm болон троян зэрэг сүйтгэгч программуд илүү боловсронгуй болохтой зэрэгцэн онцгой анхаарал татсан асуудал болж байгаа.



I LoveYou вирус

Энэ нь Пентагон, ТТГ болон Английн парламентын цахим шуудангийн системийг сүйтгэн хамгийн их хөнөөл учруулсан вирус байлаа. Вирус нь хэрэглэгчдийн Microsoft Outlook хаягийн санд байгаа хаягууд руу автоматаар илгээгэж байсан тул таньдаг хүнээсээ ирсэн и-мэйл хэмээн андууран улмаар вирусыг цааш нь маш ихээр тараасан байна.

Дэлхий даяар компьютерийн системийг вирусээс цэвэрлэхийн тулд маш их зардал гаргаж, вирусыг зохиосон этгээдийг олж тогтоосон ч тэрээр ял шийтгэлгүйгээр үлдэж чаджээ. Тухайн вирусыг 2000 оны 5 дугаар сард гаргахад Филиппинд энэ асуудлыг зохицуулсан ямар нэгэн хууль байсангүй. 2000 оны 6 дугаар сард тус улсын Цахим худалдааны хуулинд өөрчлөлт оруулан баталсан байна. Энэхүү хуульд компьютерын вирус тараахыг гэмт хэрэг болгон хуульчилжээ.

Эх сурвалж: Пенг Хва Анг, "Азийн Интернэтийг цагдах нь," Asian Wall Street Journal, 7 September 2000, 8.

Аюулгүй байдалтай холбоотой гол асуудлын тоонд:

- Компьютерын систем болон сүлжээний аюулгүй байдлыг хэрхэн хангах.
- Тоон буюу цахим орчинд хийгдэж буй гэмт хэргээс хэрхэн сэргийлэх

Энэхүү сургалтын 6 дугаар модуль дээр Сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал болон нууцлалын талаар дурдсан болно.

Оюуны өмчийн эрх

Тоон ертөнцөд ямар ч бүтээлийн хуулбарыг төгс төгөлдөр хийх боломж нэгэнт бүрджээ. Аналог ертөнцөд байнга тохиодог чанар муудах, өөрчлөгдөх асуудал энэ тал дээр огт гардаггүй билээ. Тиймээс ямар ч бүтээлийн төгс хуулбарыг хийх боломжтой гэдэг нь оюуны өмчийн эрхийг зөрчих үүдийг нээж байна гэсэн үг юм.

Тиймээс орчин үеийн оюуны өмчийн эрхийн асуудлаар доорх зүйлсэд анхаарал хандуулах хэрэгтэй:

- Өнөөгийн зохиогчийн эрхийн хамгаалалтыг дижитал бүтээлд хэрхэн хамруулах.
- Дижитал орчинд хэрхэн эрхийг авах, удирдах болон хамгаалах.
- Зохиогчийн эрхийн дагуу хамгаалагдсан бүтээлийг хулгайлахаас хэрхэн сэргийлэх.

Хууль бусаар хөгжим ашиглах



Дэлхийн хэмжээнд хамгийн ихээр хулгайд өртдөг зүйл бол дуу хөгжим юм. iPod болон бусад төхөөрөмжийн борлуулалт нэмэгдэхийн хажуугаар CD-ны борлуулалт сүүлийн жилүүдэд эрс буурч байна. Дуу хөгжмийн хулгайг өөгшүүлж буй нэг зүйл нь залуус хоорондоо бие биенээсээ хуулах замаар хөгжим татах, хуваалцах зэрэг явдал болж байна.

Харин дууг онлайнаар татах боломж олгож буй этгээдүүдийг мөрдөн олох бүрэн боломжтой. Үүнийг боломжгүй хэмээн хүмүүс боддог нь BitTorrent болон LimeWire зэрэг сайтуудаас хүмүүс бие биенээсээ хөгжим татан авах боломж байгаагаас үүдэлтэй юм.

Энэ асуудлаар хөгжмийн эрх эзэмшигч нар хариу арга хэмжээ авсан бөгөөд эдгээрийн дундаас хамгийн шийдвэртэй арга хэмжээ авсан нь АНУ-ын дуу бичлэгийн үйлдвэрийн холбоо байсан юм. Тус холбоо нь оюутнуудыг мөрдөн шалгаж тэднийг санхүүгийн хувьд хүндрэлтэй нөхцөлд байдаг болохыг тогтоон бусдад нь жишээ болгож байжээ. Зарим тайланд дурдсанаар тус холбоо нь зарим оюутныг сургуулиасаа гаран ажил хийж, хохирлыг нөхөн төлөхийг шаардаж байжээ.

Дасгал



Танай оронд хэрэгждэг зохиогчийн эрхийг хамгаалах чиглэлийн хууль болон бусад арга хэмжээг тодорхойл. Эдгээр нь тоон буюу дижитал орчинд хэр хэрэгжиж буйг үнэл.

Хувийн нууцлал

Хамгийн хүчирхэг хувийн нууцлалын дэглэм нь ЕХ-ны мэдээлэл хамгаалах зааварчилгаа бөгөөд үүний дагуу гуравдагч талууд ЕХ-ноос хүлээн авсан мэдээллийг боловсруулахаас өмнө хангалттай хэмжээнд мэдээллийг хамгаалах арга хэмжээг авсан байх ёстой байдаг. Гэхдээ АНУ-ын Засгийн газар үүний ижил дэглэмийг бий болгохоос татгалзсаны

улмаас энэ нь бүрэн хэрэгжээгүй байна. АНУ нь үүний хариу болгон “аюулгүй боомт” хэмээх зарчмыг санал болгосон нь дээрх зааврыг даган мөрдөж буй хэн бүхнийг аюулгүй боомтод байгаа хэмээн үзэж, зааварт нийцсэн хэмээн тооцож байхыг санал болгожээ.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага нь Европын холбооны шаардлагатай харьцуулбал шаардлага багатай хувийн нууцлалын зааварчилгааг мөн боловсруулан гаргаад байна²¹.

Хувийн нууцлалыг зохицуулахад хамаарах бол асуудал нь хувь хүний мэдээллийг төрийн болон хувийн байгууллагууд хэрхэн ашиглах вэ гэдэгтэй холбоотой.



Европын Холбооны стандартад нийцүүлэх нь

Хувийн нууцлалын талаарх Европын Холбооны /ЕХ/-ны байр суурь тун сайн боловсруулагдсан байдаг. Үүний шаардлагуудын нэгэнд ЕХ-ноос хүлээн авсан мэдээллийг бүхлээр нь болон хэсэгчилсэн байдлаар тухайн улс нь ЕХ-ныхтой ижил хэмжээний хамгаалалтгүй бол өөр улсад дамжуулахгүй байхыг шаарддаг байна. Практик дээр нислэгийн мэдээлэл зэрэг зарим зүйл дээр арай хөнгөлөлттэй ханддаг. Гэхдээ ЕХ-ны бодлогоос үүдэн олон орон өөрсдийн мэдээллийн хамгаалалтыг сайжруулан ЕХ-ны шаардлагад нийцүүлсэн билээ.

Мэдээж ЕХ-ны энэхүү шаардлага нь бизнесийн зардлыг нэмэгдүүлдэг. Гэхдээ бизнесийн байгууллагууд ямартаа ч энэхүү шаардлагад нийцэхийн төлөө ажилладаг ажээ.

АНУ нь аюулгүй боомтын бодлогоо зарим талаар хэлэлцэн тохироод буй бөгөөд үүнийг хувийн хэвшил гүйцэтгэж байна. АНУ-ын энэхүү бодлого нь мэдээлэл хамгаалах стандарт нь ЕХ-ны стандартад нийцэж буй компанийг ЕХ-ноос ирсэн мэдээллийг хүлээн авч боловсруулах эрх олгох тухай юм.

Австралид Засгийн газар нь өөрийн нууцлалын хуулийг шинэчлэн ЕХ-ны түвшинд хүргэхээр ажиллаж байна. Гэхдээ бизнесүүдийн лоббиноос хамааран энэхүү заалтыг хэлэлцэн батлах ажил сааталд ороод буй билээ.

Тиймээс одоогоор бизнесийнхний сонирхол болон ЕХ-ны шаардлагын хоорондын тэнцлийг хангах асуудал тулгараад байна.

http://ec.europa.eu/justice_home/fsj/privacy/index_en.htm дээр илүү мэдээлэл, холбоос байгаа болно.

Дүгнэлт

Дээр дурдагдсан Интернэттэй хамаарах асуудлуудад хандах хандлага нь үндсэндээ олон улсын хэм хэмжээ бөгөөд учир нь Интернэт нь олон улсын чанартай тул ямар ч улс үүнээс тусгаар байх боломж үгүй юм. Улмаар салбарын төлөөлөл, иргэний нийгэм зэрэг талуудтай зөвлөлдөн иргэд олон нийтийг тухайн асуудлын талаар мэдлэгтэй болгох шаардлагатай байна.

21. http://www.oecd.org/documen t/18/0,2340,es_2649_34255_1815186_1_1_1_1,00.html.

Дасгал



Дээр дурдсан 6 ангилал асуудал танай орны хувьд хэрхэн эрэмбэлэгдэхийг тогтоо. Хэрэв энд дурдсан эрэмбэ танай орны хувьд тохирохгүй бол тэдгээрийг хэрхэн ач холбогдлоор нь эрэмбэлж болохыг тодорхойл.

Өөрийгөөшалгах нь



1. Интернэтийг зохицуулах 4 төрлийг нэрлэнэ үү? Интернэтийг зохицуулахад тэдэнд ямар сул тал, хязгаарлалтууд байдаг вэ?
2. Интернэтийг зохицуулахад санал болгож буй ерөнхий төлөвлөгөө нь зөвхөн санал болгож буй зүйл юм. Энэхүү ерөнхий төлөвлөгөөний хүрээнд ямар алхамууд багтаж болох вэ?

4. ИНТЕРНЭТИЙН ЗАСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2- ИНТЕРНЭТИЙН ЗҮЙ БУС ХЭРЭГЛЭЭ

Энхүү бүлэг нь Интернет дэхь өргөн тохиолддог зүй бус хэрэглээ, хүчирхийлэл болон тэдгээрийг шийдэхийн тулд ямар үйл ажиллагаа явуулж болох талаар судлах зорилготой.

4.1 Интернет юугаараа онцлогтой вэ?

Зарим хүмүүс Интернет нь оффлайн ертөнцийн тусгал хэмээн үздэг тул үүнд тусгай заавар, журам шаардлагагүй хэмээдэг. Гэхдээ энэхүү үзэл нь Интернетийн хэд хэдэн онцлог талыг харгалзан үзээгүй байдаг.

Нэгдүгээрт Интернет нь хэрэглэгчид нэрээ нууцлах боломжийг олгодог. Мэдээж хууль сахиулах байгууллага хэрэглэгчдийг тогтоох боломжтой. Гэхдээ ингэхийн тулд онцлог хүчин чармайлт, нөөц эх үүсвэр шаардлагатай. Нэрээ нууцлахын давуу тал нь нээлттэй, шударга харилцаа холбоог, жишээ нь эрүүл мэндийн асуудлаар бий болгодог. Гэхдээ нэрээ нууцлах нь гэмт хэрэгтнүүдэд ч мөн сайн боломж болдог.

Хоёрдугаарт Интернетэд хууль үл баримтлах болох анархи байдалтай байх соёл түгээмэл байдагийг Жон Перригын "Кибер орон зайн эрх чөлөөний тунхагаас" харж болно:

Аж үйлдвэржсэн орнуудын Засгийн газруудад хандан хэлэхэд би оюун санааны орон зай болох кибер орон зайн төлөөлөл билээ. Ирээдүйн нэрийн өмнөөс биднийг тайван орхихыг хүсэж байна. Та бүхэнд энд байх шаардлагагүй. Бидний цуглах газарт та нар давуу эрх эдлэхгүй²².

Мэдээж энэхүү тунхаг нь бодит бус мөрөөдөл бөгөөд хуулийг үл ойлгодог болохоо харуулсан тусгал юм. Хууль орон зайг захирах бус харин үүнд байгаа хүмүүсийг захирдаг билээ. Хүмүүс байгаа л бол тэдний эрх үүргийг заагласан хууль байх ёстой бөгөөд ингэснээр нийгмийн үйл хөдлөлд түлхэц болж өгдөг.

Гуравдугаарт бид дөнгөж суралцаж эхлэх шатандаа явж буй бөгөөд Интернетийн сүлжээний хүчирхэг аргачлал юм. Үүний жишээ нь MySpace болон FaceBook зэрэг багтах ба одоо Web 2.0 зэрэг багтаж болно. Web 2.0 гарсанаар жижиг бүлгүүд нэгэн, дэлхийн хэмжээнд тодорхой сүлжээ үүсгэх боломжтой юм. Үүний жишээнд barefooters.org орох бөгөөд энэхүү сүлжээний гишүүд нь албан ёсны үйл ажиллагаанаас бусад тохиолдолд хөл нүцгэн явцгаадаг байна. 1999 онд дэлхий даяар 400 гаруй сүлжээний дэмжигчид байсан бол 2007 он гэхэд энэ тоо 2 000 хүрч олон оронд гишүүдтэй болжээ.

Үүнтэй ижил байдлаар Интернет нь нийтээр цугларан, үймээн үүсгэх дуртай хүмүүст ихээхэн боломжийг олгож байдаг.

22. John Perry Barlow, "Кибер орон зайн эрх чөлөөний тунхаг" (1996 оны 2 сарын 8), <http://homes.eff.org/~barlow/Declaration-Final.html>.

4.2 Интернэтийн зүй бус хэрэглээ

Хүүхдийн порнограф

Анхны үедээ хүүхдийн порнограф нь оффлайн үйлдэгдсэн зүйлийг Интернэтэд электрон хэлбэрээр оруулах байдлаар явагдаж байсан ч технологи сайжрах тусам Интернэтээр захиалга өгөн шууд үзэх боломжтой болжээ²³.

Хүүхдийн порнографыг түгээж буй бүлгийг зогсоохын тулд олон улсын хамтын ажиллагаа ихээхэн чухал юм. Олон улсын хамтарсан үйл ажиллагаа явуулан 1999 онд Кафедрал операци, 2002 онд Оре операцийг Интерполоос²⁴ явуулсан билээ. Хүүхдийн порнограф нь дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн Интернэтийн гэмт хэрэг тул олон улсын хамтын ажиллагаа ихээхэн чухал үүрэгтэй.

Хэрэглэгчдийг залилах

Интернэтийн үйл ажиллагаанаас харахад заримдаа оффлайн ертөнцөд үйлчилдэг хуулийг шинэ эдийн засагтай нийцүүлэн өөрчлөж байх шаардлагатайг харуулдаг. Дуудлага худалдааны хууль үүний нэгэн жишээ байж болно. Их Британийн хамтын нөхөрлөлийн гишүүн олон оронд дуудлага худалдааг заавал лиценз бүхий этгээд эрхлэн явуулах ёстой байдаг. Гэтэл энэ заалт нь шинэ эдийн засагт тохиромжгүй, хуучирсан заалт юм. Энэ хуулийн дагуу eBay сайт дээр дуудлага худалдаа явуулж буй этгээд болгоныг лицензтэй эсэхийг нь шалгах шаардлагатай болно. Үүнийг мэдэрсэнээр тухайн хуулийг өөрчлөн цахим дуудлага худалдааг либералчилсан ч үүнтэй зэрэгцэн дуудлага худалдааны залилангийн гэмт хэрэг ихээр гарах болжээ²⁵.

Хэрэглэгчдийг залилан мэхлэх нь дэлхий нийтийн хэмжээнд таслан зогсоох ёстой гэдэг дээр санал нэгдсэн нэгэн гэмт хэрэг билээ. Ийм төрийн гэмт хэргийг зогсоох үйл ажиллагааг 1996 оноос Интернэтийн ютилитийг сайжруулсанаар эхэлсэн бөгөөд түүнээс хойш жил болгон Интрнет дээр ийм төрлийн гэмт хэргийг цэвэрлэгээг хийж байна. Энэхүү цэвэрлэгээнд хамрагдаж буй улсуудын тоо ч сүүлийн үед нэмэгдсээр байна.



Хэрэглэгчдийн жил тутмын цэвэрлэгээ

Олон улсын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, хэрэгжүүлэх сүлжээний хүрээнд дэлхийн 40 гаруй орон хамтран онлайн байдлаар хэрэглэгчдийг хууран мэхлэх, залилах үйл ажиллагаатай тэмцэж байна. Дээрх сүлжээ нь жил тутам Интернэтийн цэвэрлэгээний өдрийг зохион байгуулан хэрэглэгчдийн зүгээс гомдол гаргасан вебсайтуудыг цэвэрлэдэг байна.

Гэхдээ ийм төрлийн цэвэрлэгээ нь оффлайн хэрэглээнд хэрэглэгдэж буй хуулиуд хэрэглэгчдийн эрхийг хамгаалах талаар заалт бүхий байгаа тохиолдолд явагдаж болно. Иймээс өндөр хөгжилтэй орнууд энэхүү цэвэрлэгээнд илүү идэвхтэй оролцдог байна.

<http://www.icpen.org> сайтыг үзнэ үү.

23. Ethel Quayle and Max Taylor, Child Pornography: An Internet Crime (New York: Brunner-Routledge, 2003)

24. Ангийг үзнэ үү (2005)

25. Ангийг үзнэ үү (2005)



Асуулт

Танай улсад хүүхдийн порнограф болон хэрэглэгчдийг залилан мэхлэхтэй холбоотой хууль хэр хэмжээнд хэрэгждэг вэ?

Спам, скам, аюултай код (malicious code), фишинг

Сүүлийн жилүүдэд улс төр, эдийн засгийн үүднээс илүү ихээр сонирхол нэмэгдэж буй нэгэн асуудал нь спам буюу олон тоогоор илгээгддэг арилжааны мейлүүд билээ. Учир нь энэхүү спам нь их хэмжээгээр түгээгдсэнээр сүлжээний хурдыг бууруулдаг. Хамгийн чухал нь спам нь хуурамч кодтой байж, фишинг хийдэг тул үүгээр дамжуулан хэрэглэгчийн нэр, нууц үг, зээлийн картын мэдээлэл зэргийг энгийн найдвартай эх үүсвэрээс илгээгдсэн мэдээллийн нэрээр халхавчлан хулгайлах оролдлого ихээр хийгдэх болжээ.²⁶

Их сургуулиудаас үүсэлтэй спам нь анхлан нээлттэй, найдвартай эх үүсвэрээс эхэлсэн түүхтэй. Эхэн үедээ хэрэглэгч нар (АНУ-ын их сургуулийн) өөрийн жагсаалтад байгаа бүх хаяг руу зарын мейл илгээн өөрийн нэр, утасны дугаараа үлдээдэг байжээ. Харин өнөөдөр Интернэт нь олон нийтэд нээлтэй болсоноор энэхүү аргачлалыг дайралт хийх хэрэгсэл болгон ашиглах болсноор барахгүй өөрийн нэр, утасны дугаарыг дурдсанаар бусдаас ихээхэн дайралтад өртөх болжээ.

Хамгийн анхны спамерыг Дижитал эквипмент корпораци (DEC) буюу Интернэтд зориулсан бичил компьютер үйлдвэрлэгч компани явуулж байжээ. Тухайн үед хэрэглэгчид гомдол гаргаж, спамерыг хялбархан олж байжээ²⁷.

Өнөөдөр хамгийн өргөн хүрээнд тархсан спам нь мейл спам бөгөөд энэхүү хэллэгийг Интернэтийн хэрэглээ болох мессеж, Usenet групп, хайлтын програмууд, блог, вики, гар утасын мессеж болон тоглоом зэрэгт хамааруулан ойлгох болжээ. Олон улсын хэмжээнд мейл спамерыг 'unsolicited bulk e-mail' буюу тодорхойгүй хаягаас ирсэн мейл хэмээн нэрлэх болсон. Үндсэндээ мейл нь хүлээн авагч тал нь хүлээн зөвшөөрөөгүй зүйлийг ч илгээж болох систем юм. Тиймээс спам нь контентын холбоотой бус харин зөвшөөрөлтэй холбоотой асуудал билээ²⁸.

26. Wikipedia, "Phishing," <http://en.wikipedia.org/wiki/Phishing>.

27. Brad Templeton, "Reaction to the DEC Spam of 1978," <http://www.templetons.com/brad/spamreact.html>.

28. Spamhaus, "The Definition of Spam," <http://www.spamhaus.org/definition.html>.



Спам- хэзээ дуусах вэ?

Спамтай холбоо бүхий асуудлыг зохицуулахаар оролдсон анхны хууль нь АНУ-д 2003 онд гарсан CAN-SPAM хууль буюу Зөвшөөрөлгүй порнограф болон маркетингийн хууль (Controlling the Assault of Non-Solicited Pornography and Marketing Act) юм. Энэхүү хууль нь хувь хүмүүс, иргэдийн эрхийг нэмэгдүүлж, АНУ дахь спам операторуудын мөрдөн шалгах зорилгоор хийгдэж байжээ. Тус хуулийн үнэлгээг 2005 онд хийсэн бөгөөд үүнд ямар нэгэн өөрчлөлт оруулаагүй байна. Гэхдээ АНУ нь спамын хэмжээгээрээ дэлхий дахинд эхний нэг, хоёрдугаарт орж буй орон билээ. Түүнчлэн Хятад болон Солонгос улс энэ хэмжээгээрээ ихээхэн өндөрт тооцогдож байна. Спам нь Интернэтээр илүү ихээр тархаж байгаагийн тоонд хууль тогтоомж сул, хэрэгжүүлэх байдал нь хангалтгүй Солонгос болон Хятад улсуудад илүү түгээмэл байна.

Бизнес эрхлэгчид болон зохицуулагч нарын эвсэл Лондонгын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу спамтай тэмцэх үйл ажиллагаа явуулж (<http://www.londonactionplan.org>) буй бөгөөд мөн Спамыг зогсооё эвсэл ажиллаж байна. Эдгээрийн талаарх мэдээллийг вебсайтаас нь үзнэ үү.

Кибер хүчирхийлэл, кибер доромжлол, хулгай болон Интернэтэд донтох үзэгдэл

Энэхүү хэсэгт дурдагдсан сөрөг талууд нь онлайн хэрэглээнээс үүдэлтэй. Хэн нэгэн этгээд онлайн байдалд удаанаар ажилласнаас үүдэн үүсэх магадлалтай юм. Кибер хүчирхийлэл нь Интернэт болон бусад электрон хэлбэрийн харилцаа холбоог ашиглан, бусдыг дээрэлхэх болон хүчирхийлэх үзэгдэл юм. Ихэнх тохиолдолд дарамталсан, доромжилсон мессеж илгээх байдлаар хийгддэг.

Кибер доромжлол нь Интернэт болон харилцаа холбооны бусад цахим хэлбэрийг ашиглан бусдыг доромжлох үзэгдэл юм. Ихэнхдээ энэ нь оффлайн хэлбэрийн үргэлжлэл байдаг.

Хулгай (хувь хүний мэдээллийн) нь хүний хувийн мэдээллийг өөртөө ашиглах болон зарим үүргээсээ зайлсхийх зорилгоор хийдэг. Үүний түгээмэл жишээнд тухайн хүний зээлийн картын талаарх хувийн мэдээллийг ашиглах явдал юм.

Эдгээр сөрөг үзэгдлүүдийн хор уршиг нь ихээхэн ноцтой бөгөөд кибер доромжлолоос үүдэн нэгнийхээ амь насыг хөнөөсөн хэрэг ч гарч байжээ. Үүний шийдэл нь үүнтэй тэмцэх хуулийг батлан гаргах явдал юм.

Интернэтэд донтох үзэгдэл нь сургууль, ажил дээрээ Интернэтийг ихээр хэрэглэснээс үүдэх бөгөөд энэ талаар Солонгост зөвлөх үйлчилгээ хүртэл ажиллуулж байна.



Интернэтэд донтох үзэгдэл

Мөрийтэй тоглоом зэрэг байдлаар Интернэтэд донтох байдал ихээр гарах болсон нь сүүлийн үед ихээхэн анхаарал татах болжээ. Донтогсад нь өдөрт 17- 18 цагийг Интернэтэд өнгөрүүлж байна. Хятад, Япон, Солонгос, Тайван улсуудад ийм явдал өндөр байгаа нь соёлын хүчин зүйлтэй холбоотойгоор тайлбарлагдаж болох юм. Одоо энэ талаар судалгаа шинжилгээний ажил үргэлжлэн хийгдэж байгаа.



Дасгал

Танай байгууллага, танай улс болон нийгэмд спам, скам, фишинг, кибер хүчирхийлэл, доромжлол, хулгай, Интернетд донтох зэргийн талаарх мэдлэг ямар түвшинд байгаа болохыг үнэл. Өөрийн үнэлгээг баримтаар баталгаажуул

Улс төрийн хүсэл зориг

Интернэтийн сөрөг үзэгдлүүдтэй тэмцэхэд улс төрийн хүсэл зориг шаардлагатай. Юуны өмнө дээр дурдагдсан үйлдлүүдийг албан ёсоор хууль бус хэмээн хуульчлах ёстой. Зарим улсад хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хууль нь оновчтой бус, хэрэгжилт нь ч тааруухан байдаг. Хоёрдугаарт олон улсын хэмжээнд хамтран ажиллах улс төрийн хүсэл зорилго ихээхэн чухал. Нигерийн 419 тоо скам нь Засгийн газраас нь ямар нэгэн зохицуулалт хийдэггүйгээс болон үүсчээ. Үүнээс үүдэн Нигерийн цахим худалдаанд итгэх итгэл ихээр буурчээ.



Урьдчилсан төлбөр буюу Нигерийн 419 дүгээр залилан

Дэлхийн хэмжээнд авлигын индексээр хамгийн доогуур байрт жагсдаг Нигер улсасаас гаралтай Интернейг ашиглан хийх залилан худал мэдээлэл ашигласан хөрөнгөжих хэмээх томъёолсон хуулийн заалтынх нь дугаараар нэрлэжээ. Нигерийн 419 дүгээр залилан нь томоохон хэмжээний мөнгө амлан үүний урьдчилгаа төлбөрийг хийлгүүлэх байдлаар залилдаг залилан билээ. Хэн нэгэн хүнд ихээхэн хэмжээний мөнгө амлах бөгөөд тухайн мөнгийг түүний тусламжтайгаар авах боломжтой болохыг илэрхийлсэн захидал ирдэг. Тухайн мөнгө нь хуучин төрийн тэргүүнүүдийн хүүхдүүд өв залгамжлан авсан мөнгө нь гадны банкинд байгаа, эвсэл хахуульд авсан мөнгө ч хэмээн итгүүлдэг бөгөөд тухайн мөнгийг авахад тусалсан тохиолдолд ихээхэн хэмжээний мөнгө амладаг. Үүнийг зөвшөөрсөн тохиолдолд тодорхой саад гарсан тул мөнгө илгээхийг хүсэх байдлаар залилдаг.

Ихээхэн хэмжээний мөнгөтэй холбоотой тул үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд зохион байгуулан зарим тохиолдолд төрийн албан хаагчид ч холбогддог. Үүнийг шалгахар Нигер явсан хүмүүс сураггүй алга болох болон алуулах тохиолдол их гардаг.

Энэ талаар Wikipedi дээр “Урьдчилсан төлбөрийн залилан” гарчигтайгаар (http://en.wikipedia.org/wiki/Advance_fee_fraud) нарийн тодорхой мэдээлэл өгсөн байгаа. Америкын компанийн вебсайт дээр ийм төрлийн захиа авсан бол юу хийхийг зөвлөсөн байдаг. (<http://home.rica.net/alphae/419coal/>)

4.3 ХОРИГ

Засаглалтай холбоотой ямар ч асуудал нь юуны өмнө журам заавруудын хэрэгжилтийг шаарддаг. Хэрэгжилтгүй бол журам заавар нь зүгээр л нэг энгийн жишээ байж болох бөгөөд үүнийг яаж ч гуйвуулж болно. Энэхүү бүлэг нь Интернетд баримтлах журмыг зөрчсөн бол хэрхэн хориг, шийтгэлийг хүлээлгэх талаар тусгасан болно.

Кибер орчны хэм хэмжээ: Сүлжээний ёс зүй (Netiquette) болон сүлжээний нийгмийн баримтлах шийтгэл

Кибер орон зай дахь бүлгүүд өөрийн гэсэн баримтлах журам заавартай байдаг. Ийм төрлийн хэм хэмжээний хамгийн хүнд шийтгэл нь тусгаардах болон хөөх шийтгэл байж болно. Үүний жишээ нь тоглоом тоглож байхдаа хоёр тоглогчийг доромжилсон, хүчирхийлсэн Mr. Bungle-ийн жишээ байж болно. Түүнийг сүлжээнээс тусгаарлан гаргаж байжээ²⁹.



Кибер орон зайн хүчирхийлэл

Онлайн бүлгүүд Интернет гарахаас ч өмнө оршин тогтнож байжээ. Тухайн бүлгүүд нь тооны хувьд цөөн байсны дээр гол харилцаа нь текст хэлбэрээр явагдаж байв. Үүнийг онлайн тоглоом дээр хэрэглэгдэж байсан бөгөөд өнөөгийн World of Warcraft зэрэг тоглоомын өмнөх үеүүд юм. Эгээр тоглоомын нэг болох LambdaMOO дээр Mr. Bungle хэмээх нэртэй тоглогч бусдын нэрээр өөртөө текст явуулж энэхүү текстдээ секс үг хэллэг ашиглаж байжээ. Энэхүү үйл ажиллагаа нь сүлжээний хэм хэмжээнээс хэтэрсэн тул түүнийг гаргаж байжээ.

Хэд хоногийн дараа LambdaMOO тоглоомын хэрэглэгчид онлайн уулзалт хийж түүний эсрэг авах арга хэмжээг хэлэлцжээ. Үүний дараагаар мастер програмчдын нэг нь Mr. Bungle хэмээх нэрийг хассан байна. Түүнээс хойш LambdaMOO тоглоомын хэрэглэгч нар ийм төрлийн тоглогч нарыг тоглоомоос гаргадаг болжээ.

Гэхдээ ийм төрлийн бүлгүүд нь цөөхөн байдаг бөгөөд учир нь тухайн нэгэн гишүүний хийсэн үйлдэл нь буруу болох тал дээр санал зөрөлдөөн ихээр гардаг. Түүнчлэн тусгаарлах нь зарим хүмүүсийн хувьд тийм ч хүнд шийтгэл болохгүй тул ийм төрлийн шийтгэл нь зөвхөн тодорхой хязгаарлалттай хэрэгждэг ажээ.

Өөртөө туслах

Зарим тохиолдолд кибер гэмт хэрэгт өртсөн этгээдүүд өөртөө туслах үйл ажиллагааг явуулах шаардлага гардаг. Жишээ нь зохиогчийн эрх эзэмшигчид ийм төрлийн үйл ажиллагааг идэвхтэй явуулдаг. Энэ нь мөрдөн шалгах болон эрх зүйн арга хэмжээ авах үйл ажиллагааны ихэнхийг зохиогчийн эрх эзэмшигчид явуулдаг гэсэн үг бөгөөд энэ тохиолдолд цагдаа бус харин эрх эзэмшигчид үйл ажиллагааг эрхлэн явуулдаг байна.

2000 онд Сиднейн олимпын зохион байгуулах хороо Copyright Control Services хэмээх компанитай гэрээ байгуулан зөвшөөрөлгүй сайтууд олимпын тухай мэдээлэл тараах үйл ажиллагааг хянасан байна. Үүний шалтгаан нь олимпыг дамжуулах эрхийг өндөр үнээр буюу 200 сая ам доллараар зарсан байсан тул зөвшөөрөлгүйгээр мэдээлэл ашиглах нь хууль бусд тооцогдож байв. 60 гаруй хүн Интернетийг хянан томоохон хэмжээний хууль бус дамжуулалтыг илрүүлж байжээ. Оросын TV6 хэмээх телевиз мэдээлэл авах эрхтэй холбоотойгоор заргалдсан ч гэсэн удалгүй дамжуулахаа зогсоох шаардлагатай болсон байна³⁰. Үүнээс хойш зуны болон өвлийн олимпын тоглолтуудаар ийм төрлийн хамгаалалт хийдэг болжээ.

29. Julian Dibbell, "Кибер орон зай дахт хүчирхийлэл," The Village Voice, 23 December 1993, http://www.juliandibbell.com/texts/bungle_vv.html.

30. "Violators caught as Olympic video monitored on Internet," CNN, 22 September 2000, <http://edition.cnn.com/2000/TECH/computing/09/22/olympics.netpolice.ap/index.html>.

Олон улсын хууль

Кибер гэмт хэргийг мөрдөн шалгах болон эрэн сурвалжлах олон улсын хуулийг боловсруулах талаар яригдаж байна. Үндсэндээ энэхүү хууль нь кибер гэмт хэргийг тодорхойлох, мөрдөн шалгах болон хэрэгжүүлэх нэгдсэн хууль болох юм. Энэ хүрээнд олон улсын хамтын ажиллагаа явагдаж буй ч оролцож буй улсуудын тоо одоогоор цөөн байгаа юм.

Кибер гэмт хэргийн талаарх Европын зөвлөлийн конвенц нь ийм төрлийн хууль гаргах нэгэн оролдлого юм. Энэхүү конвенц нь хуулийн хэрэгжилт болон үзэл бодлоо илэрхийлэх эрхийн тэнцлийг хангах юм.



Европын Зөвлөлийн кибер гэмт хэргийн конвенц

Кибер орон зайд өөрийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулахын тулд хууль сахиулах байгууллагууд Интернэтийн үйлчлэх хид хязгаарыг сайтар харгалзан үзэх ёстой билээ. Хууль сахиулах байгууллагууд бүх нийтэд, бүх оронд үйлчлэх нэгдмэл заавар журмуудыг гарган батлахгүй бол мөрдөн шалгах үйл ажиллагаа ихээхэн хэцүү байх юм.

Интернэтийн хувьд хууль сахиулах талаар зарим асуудалтай бөгөөд учир нь Интернэт дээрх бүх контент үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний илрэл байх ёстой хэмээн үздэг. Мөн Интернэт нь зөвхөн хөгжлийн үедээ байгаа тул батлан гаргасан хууль нь хөгжлийг удаашруулж болно хэмээх үзэл бас байна.

ЕЗ-ийн кибер гэмт хэргийн талаарх конвенц нь энэхүү асуудалд хандсан байдаг. Европын зөвлөлдтүс тивийн бараг бүх орон хамаардаг бөгөөд Европын холбооны гишүүдээс илүү тооны гишүүн орнууд байдаг. Европын зөвлөлөөс гаргасан дүрэм, журмыг гишүүн батлахгүй ч байж болох бол Европын холбооны хувьд гарсан шийдвэрийг өөрийн орны хуулинд тусгах ёстой байдаг.

Энэхүү холбоонд хамрагдах улсын тоо олон тул (бараг 50) кибер гэмт хэрэгтэй тэмцэх хууль гаргах нь ихээхэн асуудалтай тулгарчээ. Европын зөвлөл нь бүс нутгийн байгууллага ч соёлын хувьд ижил төстэй орнууд байдаг тул тулгараад буй асуудлуудыг шийдэх үйл явц нь хүндрэл багатай байжээ. Түүнчлэн тухайн конвенцийг улсууд хэрэгжүүлэх, батлахдаа хэсэгчилсэн байдлаар хэрэгжүүлж болдог. Үүнийг тухайн улсуудын парламент дангаар хэлэлцэн шийдэх боломжтой билээ. Харин Европын холбооны гаргасан журмыг гишүүн орнууд заавал хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.

Европын зөвлөлийн журам нь олон орнуудын үзэл бодлыг тэнцэтгэн хамруулсан. Кибер гэмт хэргийн тухай конвенц нь олон улсын хэмжээнд хэд хэдэн удаа хэлэлцэгдсэн ба Америкын иргэний эрх чөлөөний холбоо зэрэг байгууллага өөрийн саналаа өгсөн ажээ. Конвенц нь гишүүн орнууд кибер гэмт хэрэгтэй холбоотой хуулийг хэрэгжүүлэхэд нь зориулан зааварчилгаа гаргажээ. Энэхүү баримт бичиг нь 2004 оны 6 дугаар сараас эхлэн хэрэгжиж эхэлсэн. Үүн дээр олон улсын хамтын ажиллагааны талаар бүлэг байгаа нь Европын зөвлөлийн бус улсууд ч тухайн конвенцэд нэгдэн орж болох юм. Үүний үр дүнд энэхүү конвенц нь мөн 2007 оны 1 дүгээр сараас АНУ-д хэрэгжиж эхэлжээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг Европын зөвлөлийн “Кибер гэмт хэрэг: ардчилсан, хүний эрх болон хууль ёсны засаглалд үзүүлэх аюул” хэмээх баримт бичгээс үзнэ үү. http://www.coe.int/t/dc/files/themes/cybercrime/default_en.asp.

Олон улсын хэмжээний зөвшилцөлд хүрэх өөр нэгэн боломжит арга зам нь Интернэтийн засаглалын форумын хүрээнд эвсэл байгуулах явдал байж болох юм. Энэ нь тодорхой бүлгүүд, тодорхой асуудлаар нэгдэж ажиллах явдал бөгөөд үүний хүрээнд спамтай тэмцэх бүлэг идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй билээ.



”Спамыг зогсооё” эвсэл

Спамын үүсгэж буй асуудал нь илгээж буй нь бус харин хүлээн авч буй этгээд нь зардлыг нь гаргадаг бөгөөд энгийн зар сурталчилгаанд энэ нь өөр байдаг. Олон тооны судалгаагаар ихэнх мейлийн урсгалд спам ихээхэн хэмжээтэй байдаг ажээ.

Спамын анхны хувилбарын хувь хэрэглэгчид болон системийн администраторууд хялбархан филтердэх боломжтой байсан ч шинээр гарч буй спам нь илүү их уршигтай болоод байна. Сүүлийн үеийн спам нь аюултай код буюу мэдээлэл хулгайлах зорилготой кодыг агуулах болсон тул хэрэглэгчид хохирох нь их болоод байна. Тухайн програм нь хэрэглэгчид мэдэгдэлгүй ажиллах тул компьютерт байгаа мэдээллийг хулгайлдаг ажээ. Зарим тохиолдолд спам нь нууц үг болон бусад хувийн мэдээлэл хулгайлах зориулалттай байдаг. Энэхүү үйлдэл нь ихээхэн зохион байгуулалттай, ээдрээтэй байдаг тул ихэвчлэн эрүүгийн шинжтэй байдаг ажээ. Муур хулгана болохтой адилаар спаммерууд шинэ шийдлийг гаргаж ирдэг тул тэдэнтэй тэмцэх өмнөх аргачлал нь хуучран, шинэ аргачлал гаргах шаардлагатай болдог ажээ. Шинэ арга туршлагаа хуваалцахын тулд спамтай тэмцэх эвслийг Интернэтийн засаглалын форум дээр байгуулан энэхүү үйл ажиллагааг эрхлэж буй талуудыг хамруулан оролцуулж байна. Одоо энэхүү байгууллагыг Спамыг зогсооё эвсэл хэмээн нэрлэх болжээ. (<http://stopspamalliance.org>).



Асуулт

Танай улс Интернэтийн хүчирхийллийн асуудлаарх олон улсын хамтын ажиллагаанд хэр хэмжээнд оролцдог вэ?

Дүгнэлт

Интернэт нь ихээхэн хүчирхэг мэдээллийн хэрэгсэл болохын зэрэгцээ үүнийг мөн буруу зорилгоор ашиглах боломжтой байдаг. Тиймээс Интернэтийг буруу зорилгод ашиглагчдыг зохицуулах шаардлагатай нь ойлгомжтой.

Дэлхий нийтийн хэмжээнд нэгдсэн ойлголцол, зөвшилцөлд хүрч, Интернэтийг ашигласан гэмт хэрэг гэдгийг хэрхэн тодорхойлох талаар нэгдмэл ойлголтод хүрэх тал дээр амжилт багатай байгаа юм. Хамгийн их амжилтыг хэрэглэгчдийг хууран мэхлэх болон хүүхдийн порнографын тал дээр гараад байна.

Юуны өмнө Интернэттэй холбоотой хууль тогтоомжуудыг батлан гаргаж, хэрэгжүүлэх чиглэлд олон улсын хэмжээнд зөвшилцөлд хүрэх нь ихээхэн чухал байна. ЕЗ-ийн Кибер гэмт хэргийн талаарх конвенц цаашид харилцан зөвшилцөх болон хамтран ажиллах эхлэл байж болох юм.



Өөрийгөө шалгах нь

1. Хууль сахиулах байгууллагууд Интернэтээр үйлдэгдсэн гэмт хэргийг шалгахад ямар хүндрэлтэй тулгардаг вэ?
2. Дэлхий нийт заавал мөрдөн шалгах шаардлагатай хэмээн ямар гэмт хэрэг дээр санал нийлсэн вэ?
3. Интернэтийн үр дүнд бий болсон шинэ ямар гэмт хэргүүд байдаг вэ?
4. Интернэтээр үйлдэгдсэн гэмт хэрэгт ноогдуулах ямар шийтгэлүүд байж болох вэ?

5. ОФФЛАЙН ХЭРЭГЛЭЭГ ХАМААРАХ АСУУДЛУУД

Энэхүү бүлэгт Интернэт нь хэвийн оффлайн хэрэглээг хэрхэн хамаарч болох ялангуяа Засгийн газар, эдийн засаг болон контентын асуудлаар хэр байгаа талаар мэдлэгийг бий болгох зорилготой. Мөн энэ бүлэг нь холбогдох зохицуулалтын шаардлагатай байгаагийн учир холбогдлыг өгүүлэх болно.

Интернэт нь оффлайн хэрэглээнд ч өөрийн нөлөөг үзүүлж байна. Онлайн нөхцөлтэй нийцэхийн тулд оффлайн хэрэглээнд өөрчлөлт хийх үү эсвэл оффлайн хуулийг онлайн нөхцөлд хэрэгжүүлэх үү? Энэхүү асуулттай холбоо бүхий хариултыг энэхүү хэсгээс олж болно.

5.1 Өрсөлдөөний бодлого

Ямартаа ч аль болох боломжоороо Интернэтэд нэвтрэх эрх өрсөлдөөнтэй байх ёстой. Энэ нь харилцаа холбооны салбарыг либералчлах шаардлагатайг харуулж байна. Энэ салбарыг чөлөөлснөөр үйлчилгээний чанарыг сайжруулан, үнийг бууруулах боломжтой. Үнэ бага байснаар хэрэглээг нэмэгдүүлэх бө өргөн зурвасын хувьд үнэ бага байснаар хэрэглээний хэв шинжид өөрчлөлт оруулж болно. Тоглоомын онолоор өрсөлдөөн үр дүнтэй байхын тулд дор хаяад гурван тоглогч байх ёстой хэмээн үздэг.



Харилцаа холбоо болон Интернэтийн өртгийг чөлөөлөх нь

АНУ-д Интернэтийн хэрэглээ өндөр байгаагын нэг шалтгаан нь харилцаа холбооны салбарт өрсөлдөөн нэвтрүүлсэнтэй холбоотой хэмээн үздэг. Үндсэндээ Интернэт нь алсын зайн цахилгаан холбоон дээр суурилдаг бөгөөд энэ салбарт өрсөлдөөн нэмэгдсэнээр үнэ буурдаг ажээ. АНУ-д тухайн салбарыг чөлөөлсний үр дүнд вебсайтыг хостингын төлбөр хамгийн хямд болсон явдал юм. Үнэ хямд байснаар хэрэглээг нэмэгдүүлдэг эдийн засгийн онол ийнхүү хэрэгжсэн билээ.

Судалгаанаас үзвэл харилцаа холбооны салбарын эрэлт ихээхэн уян хатан байдаг ажээ. Энэ нь үнэ тодорхой хувиар буурахад хэрэглээ тодорхой хувиар өсдөг байна. судалгаагаар мөн цаашид Интернэтийн хэрэглээ ихээхэн нэмэгдэх төлөвтэй байгаа юм. Франц, Япон болон Солонгос улсуудад өргөн зурвасын Интернэтийн хэрэглээг өрсөлдөөний бодлогын үр дүнд нэмэгдүүлсэн байна. Солонгос улс нь дэлхийн хэмжээнд өргөн зурвасын Интернэтийн хэрэглээгээр дэлхийд тэргүүлж байна. Тус улс нь 1980 оноос хойш тоног төхөөрөмжид суурилсан чөлөөт эрхийг зөвшөөрөх болсон ажээ. Франц болон Япон улсуудад 2005 оныг хүртэл хэрэглээ тийм ч өндөр байгаагүй бөгөөд үүнээс хойш өрсөлдөөнийг дэмжих бодлого хэрэгжүүлсэнээр үнийг бууруулан, өргөн зурвасын хэрэглээг нэмэгдүүлжээ.

1980-аад оны дунд үеэс харилцаа холбооны салбарыг чөлөөлөхийн давуу талуудын талаар олон тооны ном хэвлэгдэн гарч, энэ талаар ихээр яригдах болжээ. Энэ талаар Emmanule Giovanetti: Мэдээллийн технологийн хувьсгал, Интернэт болон харилцаа холбооны салбар-Европд өрсөлдөөнт салбарт шилжсэн нь хэмээх номонд дурдсан байна.

5.2 ЦЕНЗУР БОЛОН ҮГ ХЭЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Засгийн газар болон хувийн хэвшлээс цензур тогтоох нь дэлхий даяар түгээмэл байдаг. Дээр дурдсанчлан улс бүрийн ашиг сонирхлыг олон улсын хэм хэмжээтэй тэнцвэржүүлэх нь Интернэтд тулгарч буй гол асуудал байдаг. Гэхдээ сайтуудад бөөнөөр нь хаалт хийснээр Интернэтийн ертөнцөд таагүй нөлөөг үзүүлдэг. Хамгийн боломжит, хүлээн зөвшөөрөгдөх шийдэл нь хэрэглэгч өөрөө филтердэх явдал билээ. Энэ нь хэрэглэгч өөрөө филтерийн програмыг суулган, ажиллуулах явдал юм. Гэхдээ эцэг эхчүүд ийм төрлийн филтерийг суулган хүүхдүүдээ хамгаалах нь тэр бүх хэрэгжихгүй байгаа билээ.



Сайн дурын тохиргоо бүхий филтер-шүүлтүүр

1999 онд Бертелсман сангаас Интернэтийн агуулгад филтер хийх систем боловсруулах баг ажиллуулсан ба энэхүү баг нь соёлын хувьд зохистой, үг хэлэх эрхэд үл нөлөөлөх систем боловсруулах зорилготой байжээ. Энэхүү баг нь судлаачид, зохицуулагчид болон чөлөөт эрхийн төлөөх тэмцэгч нарыг багтаасан байлаа. Тухайн баг нь улмаар Интернэтийн контентын рейтингын холбоо (Internet Content Rating Association (ICRA)) байгуулжээ.

Тус баг ямар зорилгод хүрэхээ сайн мэдэж байсан бөгөөд эцэг эхчүүд Интернэт дээр өөрийн улсын нэрийг даран, филтерийн системийг идэвхжүүлсэнээр тохиромжгүй хэмээн үзсэн сайтууд нь филтерт шүүгдэх учиртай байв. Энэхүү системээр сайтууд нь мөн өөрсдийнхөө рейтингийг гарган хэрэглэсэн хэл, хүчирхийлэл, архидалт зэрэг зохисгүй (гэхдээ хууль бус биш) агуулга байгаа эсэхийг тогтоох ба нийт 40 гаруй ийм филтерийн шошго бий болгохоор зорьсон байна.

Баг нь үйл ажиллагаа явуулсан ч энэхүү эцсийн зорилгодоо хүрч чадаагүй юм. Нэгдүгээрт иргэний эрхийн төлөөх байгууллагууд буюу АНУ-ын Ардчилал, технологийн төв зэрэг байгууллага эсэргүүцэл үзүүлсэн байна. Өөрсдийнхөө зэрэглэлийг тогтоохоор анхлан зөвшөөрсөн байсан мэдээний сайтууд ч гэсэн дараа нь үүнээсээ буцсан байна. Хоёрдугаарт чөлөөтэй үг хэлэх эрхийг хангахын тулд сайтууд өөрсдөө өөрсдийнхөө зэрэглэлийг тогтоох хэрэгтэй болсон ба үүнийг олонх вебсайтууд хүлээн зөвшөөрөөгүй байна. Тэдгээр гол сайтуудгүйгээр филтер ашиглагч нар байнга үүнийгээ унтрааж, асааж байх шаардлагатай болсон. Гуравдугаарт эдгээр филтерийг браузер буюу хөтөч дээрээ хамтатган оруулбал ихээхэн үр дүнтэй болох байсан. Тухайн үед Майкрософтын браузер ихээр хэрэглэгдэж байжээ. Тэр үеийг хүртэл Нетскейп болон Майкрософт өөр өөрийн браузер дээр нэмэлт оруулж байсан билээ. Хэрэг дээрээ Microsoft browser 2000 нь тийм ч сайн бус системтэй байсан ба үүний АНУ-д гарсан V-chip зэрэг системийн адилаар хэрэглээ, эрэлт ихээхэн муутай байсан билээ.

2007 онд Интернэтийн агуулгын рейтингын холбоо нь Family Online Safety Institute болон өөрчлөгдсөн билээ.

Энэ номын зохиогч нь Интернэтийн контентын рейтингын холбооны Удирдах зөвлөлийн гишүүн байсан ба энэ асуудлаар анхлан Эмх цэгцгүй байдлыг зохион байгуулалтад оруулах нь номондоо Интернэтийн контентын рейтингын холбооны талаар дурдсан байдаг.

Өөр нэгэн хандлага нь серверийн филтер байсан бөгөөд энэ нь хэрэглэгчдэд өртөг нэмсэн бүтээгдэхүүн байдлаар зарагдаж болох юм. Мэдээж шинэчлэх болон хаалттай сайтуудын жагсаалтыг авахад төлбөр төлөх юм. Энэ нь энгийн хэрэглэгч өөрчлөлт оруудах боломжгүй филтер бөгөөд харин сул тал нь зарим тохиолдолд энгийн сайтуудыг ч блоклох ба эргүүлэн блокоос гаргахад түвэгтэй байдаг ажээ.



5.3 НЭР ХҮНДЭД ХАЛДАХ

Интернэтээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө их байдаг тул үүнийг ашиглан бусдын нэр төрийг гутаах явдал элбэг байдаг. Ерөнхийдөө энэ асуудалд хандах гэдэг нь сэргэлдөгч сонирхлуудыг тэнцвэржүүлэх явдал буюу нэр хүндийн талаарх хувь хүний сонирхол, үе хэлэх эрх чөлөөг дээдлэх нийгмийн сонирхлыг тэнцвэржүүлэх асуудал билээ. Интернэтийн хувьд хувь хүний болон нийгмийн соёлыг тэнцвэржүүлэхэд соёлын үнэт зүйлс ихээхэн нөлөөтэй байдаг.

Үүнтэй холбоотой нэгэн жишээ нь Австралийн Мельбурн хотын бизнесмен Жосеф Гутникийн нэр төрийн гутаасантай холбоотой. Доу Жонс группын эзэмшдэг Barron's сэтгүүлийн нийтлэлээр түүний нэр төрийг гутаасан байна. Тус сэтгүүл нь Австралид нийт 14 захиалагчтай байснаас 5 нь Викториа мужид байсан ба энэхүү хэргийг дээд шүүх авч хэлэлцжээ³¹. Barron's сэтгүүл нь Австралийн зээлийн картаар төлбөр хийсэн 1,700 онлайн захиалагчтай байжээ. Энэ хэрэгтэй холбоотой гол асуудал нь хэрэв Гутник ялбал ийм төрлийн нийтлэл гаргаж буй бүх хэвлэл энэхүү гүтгэлэгтэй холбоотой хуулиар шийтгэгдэх үү хэмээх асуудал гарч иржээ. Харин Дээд шүүх Гутник нь нэхэмжлэл гаргахдаа нэр төрд учирсан хохирлоо дэлхий даяар учирсан тооцох бус харин Мельбурн хотын хэмжээнд л тааруулан нэхэмжлэх ёстой болох шийдвэр гаргажээ³².

31. David Fickling and Stuart Millar, "How Diamond Joe's libel case could change the future of the internet," The Guardian, 11 December 2002, <http://www.guardian.co.uk/technology/2002/dec/11/media.newmedia>.

32. Австралийн дээд шүүх, "Dow Jones and Company Inc v Gutnick [2002] HCA 56" (10 December 2002), http://www.austlii.edu.au/au/cases/cth/high_ct/2002/56.html.



Дасгал

Танай улсын иргэн Ү-д доорх зүйл тохиолджээ.

1. Танай улсад буй В-гын блог Ү-гийн нэр хүндэд халдсан байна. Тухайн блог нь олон нийтэд хэр хүртээмжтэйгээс нь ноогдох шийтгэл хамаарах уу? Ү-г хамгаалсан 200 пост байгаа бол ямар байх вэ?
2. Хэрэв АНУ-д байдаг онлайн мэдээллийн байгууллага Ү-гийн компанийн нэр хүндэд халджээ. Үүнд хамаарах дэлхий нийтийн хариуцлага гэж байх уу?

Интернэт нь хуулинд бас нэгэн өөрчлөлт оруулах шаардлага үүсгэдэг бөгөөд энэ нь гуравдагч талын контентоос бусдыг хамгаалах асуудалд юм. Энэ нь вебсайт болон форумын хост нь гуравдагч талын гаргасан ямар нэгэн агуулгын төлөө хариуцлага хүлээхгүй байх явдал бөгөөд харин үүнийг бусдын нэр хүндэд халсан гэдгийг нь мэдэгдсэнээс хойш удаан хугацаанд санаатай тараасан эсэх нь хариуцлагад хамарч болно. Ихэнх хууль тогтоомжуудад санаатай гэдэг нь тухайн бусдын нэр хүндэд халдсан агуулгыг удаан хугацаанд³³ арилгахгүй байхыг хэлдэг.

5.4 ЗОХИОГЧИЙН ЭРХ БОЛОН БУСАД ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХ

Зураг 3. Зохиогчийн эрхийг тэнцвэржүүлэх нь

(Эх сурвалж: DiploFoundation, <http://textus.diplomacy.edu/textusbin/env/scripts/Pool/GetBin.asp?IDPool=1181>)



33. Анг-ийг үзнэ үү (2005)

Дээрхтэй ижил төрлийн хамгаалалт буюу дархлааг зохиогчийн эрх дээр мөн бий болгох эрхтэй. Учир нь вебсайт болон форумын хост нь зохиогчийн эрхийг зөрчсөн агуулгын талаар ямар нэгэн хариуцлага хүлээхгүй бөгөөд харин энэ нь зөрчилтэй болохыг мэдэгдсэний дараа арилгах үүрэгтэй. Үндсэндээ олон орнууд АНУ-д хэрэглэгдэг энэхүү мэдэгдэл өгсөний дараа хаах хэмээх зарчмыг баримталж буй юм. Тухайн агуулгыг түр хааснаар зохиогчийн эрхийн асуудлыг шийдэх боломжтой.

Оюуны өмчийн талаарх ихээхэн мэдрэмтгий нэг салбар бол Домэйн нэрийг худалдааны тэмдэгт хэмээн үзэх үү гэдэг асуудал юм. Үндэстэн дамнасан компаниудын хувьд Домэйн нэрийг худалдааны тэмдэгт хэмээн үзвэл улс болгонд шинээр бүртгүүлэх зардлыг бууруулна. Гэтэл нөгөө талаар тухайн үндэстэй дамнасан компанийн нэрийг ашиглаж буй хэн боловч оюуны өмчийн эрхийг зөрчсөнд тооцогдох болж байна.

Энэхүү асуудлыг шийдэхэд олон улсын хэмжээнд Интернэтийн нэр, дугаар олголтын корпорацын маргаан таслах аргачлалыг ашиглаж болох харин улс болгоны хувьд ccTLDs-тай холбоотой тухайн улсын хуулийн дагуу шийдэх шаардлагатай.



Асуулт

1. Домэйн нэрийг худалдааны тэмдэг хэмээн үзэх ёстой юу? Яагаад?
2. Танай улсын ашиг сонирхол болон гадаадын илүү өндөр хөгжилтэй улсын зохиогчийн эрх эзэмшигчийн ашиг сонирхлыг хэрхэн зохицуулах вэ?

5.5 НУУЦЛАЛ

Дээр дурдсанчлан хувийн нууцлалтай холбоотой журмууд хэрэгжиж байх ёстой. Үүнд тавигдах гол асуулт нь: үүнийг зохицуулахын тулд ямар загвар хэрэглэх вэ гэдэг асуулт байна. Үндсэндээ хоёр загвар хэрэгжиж байгаагаас Европын загвар нь хувийн нууцийг хүний эрх хэмээн үзэх загвар байдаг. Үүнийг худалдан авч, зарж болохгүй бөгөөд үүнийг зохицуулсан хуультай. АНУ-ын загвар нь хувийн нууцийг хууль зүйн эрх хэмээн үздэг бөгөөд үүнийг гэрээлэн дамжуулж болно хэмээн үздэг. Жишээ нь хэн нэг хүний мейл хаягийг авсаныхаа төлөө хэн нэгэн этгээд зарим баримт бичгийг унших болон үйлчилгээ авч болно гэсэн үг. Үүнтэй холбоотой хууль тогтоомжууд бүрэн хэмжээгээр гарсан байдаг бөгөөд салбар бүрт өөр өөрөөр хэрэгждэг.

Интернэт дээр хэрэгжилтийн хувьд аль ч загвар нь ижил байдаг. Мэдээж Европын загвар нь илүү олон тооны арга хэмжээ, шийтгэлтэй байдаг ба ингэснээр зардлыг ихээр нэмэгдүүлдэг байна.

Алв нэг улс нь аль загварыг сонгох нь тухайн улсын соёл болон түүхээс хамаардаг. Мэдээлэл хамгаалах зааварчилгааг хэрэгжүүлсэн тохиолдолд Европын загварыг дэлхий нийтээр ашиглах боломжтой юм.



Асуулт

1. Танай улсад хувийн нууцлалыг хууль ёсны хэрэглэгчийн шаардлага хэмээн хэр хэмжээнд авч үздэг вэ?
2. Танай улс аль загварыг дагах шаардлагатай вэ? Та яагаад тэгж бодож байна вэ?

Дүгнэлт

Зохицуулалтын үйл явц нь ил тод, олон талын оролцоотой, ардчилсан байдлаар явагдах ёстой. Энэ нь тухайн үйл явц нь зөвлөлдөөнд суурилсан, үүнд бүх талуудыг хамруулсан байх ёстой гэсэн үг юм. Зохицуулалт нь бүх дөрвөн үе шат болох зах зээл, нийгмийн хэм хэмжээ, архитектур болон төрийн зохицуулалтыг (өөрийн зохицуулалт мөн хамаарна учир нь үүнийг төрөөс даалган тогтоож өгдөг) хамрах юм.



Өөрийгөө шалгах нь

1. Өрсөлдөөний бодлого Интернэтийн хэрэглээнд ямар хамааралтай вэ?
2. Интернэт дэхь хэрэглээнд цензурыг хэр хэмжээнд хэрэгжүүлж болох вэ?
3. Интернэт хэрэглэгч нь бусдын нэр төрийг гутаасныхаа төлөө шийтгэл хүлээж болох уу?
4. Нэр төрийг хамгаалахтай холбоотой хуулийг Интернэтд тохируулан өөрчлөх шаардлагатай юу?
5. Интернэт дэхь зохиогчийн эрх болон бусад оюуны өмчийн эрхийн гол асуудлууд нь ямар асуудлууд байгаа вэ?
6. Хувийн нууцлалыг хамгаалах хоёр ямар хандлага байдаг, тэд хоорондоо ямар ялгаатай вэ?

6. ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ- ТООН ХУВААГДАЛ

Энэ бүлэг нь Интернэтийг нийгэм, эдийн засгийн хөгжилд хэрхэн ашиглаж болох, мөн үүний хязгаарлалтуудын талаар мэдээлэл өгөх зорилготой.

Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд уулзалтын голлох хөдөлгөгч хүчин зүйл нь үндэсний хөгжлийн асуудал байсан ба үүнээс үүдэн Интернэтийн засаглалын талаарх хэлэлцүүлэг эхэлсэн билээ. Гэхдээ хөгжлийн асуудал нь том, өргөн хүрээний асуудал тул энэхүү асуудалд хүрэн хариулт өгөхөд ихээхэн урт хугацаа шаардагдана. МХХТ нь хөгжлийн үйл явцад өөрийн хувь нэмрийг оруулан, түргэтгэх юм.

6.1 ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ МХХТ

Үр дүнд хүрэхийн тулд хөгжлийн төлөөх МХХТ нь (а) засаглал болон чадавхи, (б) дэд бүтэц, (в) эдийн засгийн хөгжил, болон (г) нийгмийн хөгжлийн асуудлыг хамарч байх ёстой. Зөв засаглалгүйгээр зарцуулж буй хөрөнгө үр дүнд хүрэхгүй. Чадавхгүйгээр хэрэглэгчид өөрсдийгөө өөрчлөх боломжгүй. Харилцаа холбооны болон эрчим хүчний шугам зэрэг дэд бүтэцгүйгээр Интернэтийг тогтвортой хүргэх боломжгүй.

Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд уулзалт нь Дижитал нэгдлийн санг үүсгэсэн юм. МХЗ-ууд нь энэхүү санг хэрхэн зарцуулахыг заасан хамгийн сайн зааварчилгаа болдог. МХЗ-ууд нь:

1. Ядуурал, өлсгөлөнг бууруулах.
2. Дэлхий нийтээр суурь боловсрол эзэмшүүлэх.
3. Жендерийн тэгш байдлыг ханган, эмэгтэйчүүдийг чадавхжуулах .
4. Хүүхдийн эндэгдлийг бууруулах.
5. Эхийн эрүүл мэндийг сайжруулах
6. ДОХ/ХДХВ, хумхаа болон бусад өвчинтэй тэмцэх.
7. Байгаль орчны тогтвортой байдлыг баталгаажуулах.
8. Дэлхий нийтийн хөгжлийн түншлэлийг хөгжүүлэх.

Энэхүү сургалтын Модуль 1 дээр МХХТ болон МХЗ-уудын хоорондын холбоог харуулсан байгаа.



Тосгоны Интернэт

Хүчирхэг, орчин үеийн технологи болохын хувьд Интернэт нь хэрэглэж буй болон хэрэглэхгүй хүмүүсийн хоорондын орлогын тэгш бус байдлыг өргөтгөж болох юм. Тэгш бус байдал үзүүлсэн гайхалтай нөлөөллийг Энэтхэгээс харж болно. Тус улсад томоохон хотуудад л энэхүү орчин үеийн технологи нэвтрээд байсан билээ. Харин хөдөө нутагт Энэтхэгчүүдийн хэлдэгээр “мэдээллийн харанхуйд” амьдарч байсан бөгөөд телевиз ч үзэх боломжгүй байжээ.

Интернэтийн хэрэглээг түгээн, нийгэмд буй зарим асуудлыг шийдэхийн тулд Энэтхэгийн Засгийн газраас 2007 онд үндэсний хэмжээний Нийтлэг үйлчилгээний төв нэртэй цахим засаглалын төслийг хэрэгжүүлэн Энэтхэгийн 600,000 тосгоны дунд ашиглах 100,000 төвийг байгуулжээ. Хэрэг дээрээ эд нар нь Интернэт ажиллуулдаг ТҮЦ байсан юм.

Хуучин ТҮЦ нь олигтой амжилттай болоогүй бөгөөд эдгээрийн эхний давалгаа нь зөвхөн 3%-ийн амжилт олсон байна. Эхний үе шатнаас авсан сургамж дээрээ суралцсан ба дараагийн давалгаа нь 30 гаруй хувийн амжилтад хүрсэн байна. Энэ нь өмнөхтэйгээ харьцуулбал 10 дахин амжилттай байсан ч үлдэх 70 нь амжилтад хүрээгүй гэсэн үг юм. Хамгийн сүүлийн хийгдсэн судалгаагаар тосгоны иргэдэд ямар хэрэглээ, аппликейшн шаардлагатай байгаа болохыг судлан гаргаж Нийтлэг үйлчилгээний төвийг байгуулжээ.

Жишээ нь Энэтхэгийн Засгийн газар Интернэтээр дамжуулан газрын эрх олгох болсон бөгөөд өмнө нь орон нутгийн авлигад идэгдсэн албаны хүмүүс тосгоныхныг хуурах явдал их байжээ. CD бичих болон дижитал зураг хэвлэх зэрэг үйлчилгээ мөн орлого олох боломжтой үйлчилгээнд тооцогдож байв. Ченнай мужид шалгалтын материалыг онлайн байдлаар тавихад хувийн хөрөнгө оруулалт хүртэл хийгдсэн байна. Үндсэндээ тосгоны иргэд шалтгалт дээр бага оноо авдаг байсан бөгөөд материал нь онлайн болж, иргэд судлах боломжтой болсоны дараагаар дүн нь эрс сайжирчээ.

Нийтлэг үйлчилгээний төв нь үнэхээр бодитоор хэрэгжсэн санаа байсан бөгөөд нийгмийн асуудлыг шийдэхээр (жишээ нь газрыг нь хууль бусаар авах) Интернэт ашиглахаас гадна дижитал хуваагдлыг багасган ажил эрхлэлтийг нэмэгдүүлж байжээ. Интернэт ТҮЦ-ийг ажилуулж буй хүмүүс нь хувийн хэвшлийн төлөөлөл байжээ. Онолоор бол үүнээс үүдэн Засгийн газарт ноогдох зардал багассан ба орон нутгийн захиргаа тодорхой хэмжээгээр материаллаг болон санхүүгийн дэмжлэг үзүүлж байжээ.

Одоо энэхүү схемийг улам дэлгэрүүлж байгаа ба үр дүн нь цаашид тодорхой болох юм.

Дэлгэрэнгүй мэдээллийг Мэдээллийн технологийн яамны “Нийтлэг үйлчилгээний төв”-ийн хаягаар үзнэ үү, <http://www.csc-india.org>.

6.2 ХЯЗГААРЛАЛТУУД БОЛОН СААД ТОТГОРУУД

МХХТ-ийг хөгжлийн зорилгоор ашиглахад өөрийн гэсэн сул талууд, хязгаарлалтууд байдаг болохыг санах хэрэгтэй. Жишээ нь МХХТ-ийг ашигласнаар илүү сайн мэдээлэлтэй болж илүү үр дүнтэй шийдвэр гаргадаг хэмээдэг ч тэр болгон үүний дагуу болохгүй байж болно. Мөн олон тооны МХХТ нь мэдээлэл боловсруулах аргачлал байдлаар ихээхэн хэрэглэгддэг учраас харилцаа холбооны хэрэгсэл биш байж хөгжлийн гол зорилгодоо хүрэхэд нь тэр бүр түлхэц болж чаддаггүй. Мөн хэн нэгэн хүний хяналтаас гадуурх ямар

нэгэн саад тотгорууд байдаг. Хэлний асуудал нэг саад бэрхшээл байхын хажуугаар авлига ч гэсэн үүнд хамаарах бас нэгэн саад тотгорт хамаарна. Зардал ч мөн нэгэн гол асуудал хэвээр байна. Гэхдээ зардлыг бууруулж болдог. Нэгдүгээрт хямд техник хангамж зах зээл дээр ихээр гарах болсон. Хоёрдугаарт нээлттэй эх програм хангамжийн хөдөлгөөний хүрээнд үнэгүй, нээлттэй програм хангамж ихээр гарах болсон. Нээлттэй эх нь хямд байж болох ч заримдаа үүний ашиглалтын зардал өндөр жишээ нь заримдаа програмыг хэвлэх төхөөрөмжид холбох зэрэг нэмэлт зардал гарч болохыг анхаарах хэрэгтэй.

6.3 МХХТ-ИЙН ХӨГЖЛИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ПРОГРАММ

Нийтээр сайн мэддэг, өргөн хэрэглэгддэг МХХТ-ийн аппликейшн, хэрэглээний програм байдаг. Дээр дурдсанчлан тэдний ихэнх нь мэдээлэл түгээх хэлбэртэй байдаг. Ийм хэрэглээний програмыг хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэнд, аялал жуулчлалд хэрэглэж байдаг. Эдгээр салбаруудад мэдээлэл хүртээмжтэй байх нь илүү өндөр үр дүнг авчирдаг. Жишээ нь тариаланчид тухайн жил ямар ногоо тарих болон хэзээ тариалах гээд мэдээлэлтэй байвал тэдэнд тустай.

Мэдээллээс гадна харилцаа холбоо нь илүү үр дүнтэй байж болно. Жишээ нь тариаланч ногоогоо тарьсаны дараа ургацад хор учруулах хортон шавьжтай тэмцэх талаар мэдлэгтэй байх ётсой ба энэхүү мэдлэгийг илүү сайн харилцаа холбоотой байсны хүчинд олж авч болно.

Хамгийн их үр нөлөөг үзүүлдэг нь цахим засгийн үйлчилгээ юм. Үүний жишээнд виз мэдүүлэх, татвар, газрын эрх болон жолооны үнэмлэх зэрэг дээр өргөдлийн маягтыг онлайнаар гаргах боломж багтана. Үүнийг эхлүүлэхийн тулд төрийн үйлчилгээг компьютержуулах шаардлагатай. Ингэсний үр дүнд төрийн үйлчилгээний үр нөлөөг сайжруулдаг. Жишээ нь төрийн байгууллагуудаас зарлаж буй тендерийг онлайн зарласнаар мөнгө хэмнэх давуу талтай. Компьютержүүлсэнээр үйл ажиллагааг илүү ил тод болгон авлигыг бууруулна. Компьютержүүлсэнээр МТ-ийн эдийн засгийг бий болгон техникчид болон програмчдыг ажлын байраар хангах юм. Компьютержүүлэн Интернэтийн хэрэглээтэй хослуулсанаар олон нийтийн гол чухал асуудлуудаар иргэдтэй зөвлөлдөх боломжийг ханган өгнө. Ингэснээр иргэд чадавхин, хөгжлийн үйл ажиллагаа түргэснэ. *(Энэхүү сургалтын 3 дугаар Модуль нь цахим засгийн асуудлыг хөндсөн болно)*

Цахим засгийн үйлчилгээ илүү ил тод болсоноор ардчиллыг бэхжүүлнэ хэмээн үзэж болно. Гэхдээ энэ нь тэр болгон хялбар бий болох зүйл биш бөгөөд цахим засгийн хувьд эцсийн үйлчилгээ хэрэглэгчиддээ хэрхэн хүрч байгааг олж мэдэх боломжийг олгодог. Гэхдээ үүний үр дүнд илүү хариуцлагатай төрийн үйлчилгээг орон нутагт бий болгон, авлигыг бууруулдаг³⁴.

Дүгнэлт

Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд хэмжээний уузалтын нэг гол зорилго нь хөгжлийн асуудалд суурилж, улмаар Интернэтийн засаглалын ажлын хэсгийг байгуулсан билээ. Гэхдээ Ажлын хэсгийн сүүлийн тайлан дээр хөгжлийн асуудлыг хангалттай хэмжээнд авч үзээгүй харин энэ асуудлыг Интернэтийн засаглалын асуудалд илүүтэйгээр хамруулсан байлаа. Олон улсын хамтын нийгэмлэг МХХТ-ийг хөгжлийн зорилгод ашиглах төслүүдийг

34. R. Kluver, The Architecture of Control: a Chinese Strategy for e-Governance, in "The Internet and Governance: The Global Context," The Journal of Public Policy, 25, 1 (2005): 75-97.

санхүүжүүлээх замаар ихээхэн ажлыг хийж чадна. Үүний нэг жишээ нь төр- хувийн хэвшлийн түншлэл бөгөөд энэ нь санхүүжилтын зардлын хуваан гаргадаг тул төслүүдийг илүү амжилтад хүрэх боломжийг ханган өгдөг. (МХХТ-ийн салбарт төр- хувийн хэвшлийн түншлэлийг ашиглах талаар энэхүү сургалтын модулийн 8 дугаарт багтаасан) Гэхдээ улс орнуудын Засгийн газрууд МХХТ-ийг хөгжлийн зорилго ашиглахад маш олон зүйлийг хийж чадна. Юуны өмнө Интернэтийн хэрэглээний зардал хямд байх ёстой. Жишээ нь Домэйн нэрийг бүртгүүлэх зардлыг бууруулах шаардлагатай. Дараагаар нь МХХТ-ийн салбарт ээлтэй эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай. МХХТ-ийг хөгжлийн зорилгод, тэр дундаа харилцаа холбооны аргачлал байдлаар, ашиглах нь илүү их үр өгөөжтэй байх юм.



Өөрийгөө шалгах нь

1. Хөгжлийн зорилгод хүрэхэд Интернэтийг хэрхэн ашиглаж болох вэ?
2. Хөгжлийн зорилгод хүрэхэд Интернэтийг ашиглахад тулгарч буй ямар саад, хязгаарлалтууд байна вэ?

7. ИНТЕРНЭТИЙН ЗАСАГЛАЛ: ИРЭЭДҮЙГ ХАРАХУЙ

Энэхүү бүлэг нь Интернэтийн засаглалын форум шийдэх чадахгүй, боломжгүй харин Засгийн газрууд анхаарал хандуулах шаардлагатай Интернэтийн засаглалын гол асуудлуудын талаар дурдсан болно.

Интернэтийн засаглалын форумын 5 жилийн хугацаа 2010 оноор дуусгавар болж байна. Шинээр байгуулагдах форумын төлөвлөлтийн үйл ажиллагааг нэгдсэн хуралдаанаар гүйцэтгэх шаардлага гарч ирээд байгаа юм. Форумын үйл ажиллагааны давуу талууд нь ойлгомжтой, ид тод байгаа. Үзэл баримталын хувьд энэхүү форум нь томоохон асуудлуудыг хэлэлцэх болон жижиг улсууд ч асуудал оруулан хэлэлцүүлэх боломжийг хангасан билээ. Практикын хувьд форум нь Интернэтийн засаглалын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэн, энэхүү үйл явцын талаарх мэдлэгийг ихээхэн дээшлүүлсэн билээ.

Үндсэндээ Интернэтийн засаглалын бодит үйл ажиллагааны ихээхэн хэсэг нь төлөвлөлтийн төвлөрлийг бууруулсан, шинэ санааг санал болгосон паралел нөхцөлд явагдсан билээ. Зарим эвсэлүүд үйл ажиллагаагаа идэвхтэй явуулан өөрийн бүлгийн ашиг сонирхлыг хамгаалж иржээ. Жишээ нь спамтай тэмцэх үйл ажиллагаа зэрэг явагдан энэхүү асуудлыг шийдэх зорилго бүхий уулзалтуудыг хийсээр иржээ.

Ажлын хэсгийн эцсийн тайланд тусгагдсан асуудлууд нь хялбар шийдэгдэх асуудлууд биш юм. Жишээ нь олон улсын хэмжээнд Интернэтийн нэр, дугаар олголтын корпорацболон DNS-ийг хянах улс төрийн асуудлыг тусгаад байна. АНУ-ын Засгийн газар энэ удаад ялалт байгуулсан бөгөөд Интернэтийн нэр, дугаар олголтын корпорацыг хяналтдаа байлгасаар байна. Гэхдээ ccTLDs нь улс орнуудын Засгийн газрын хяналтад байгаа ч АНУ-ын Засгийн газар тэднийг энэхүү хяналтаас нь салгах бүрэн боломжтой хэвээр байгаа юм. Практик хязгаарлалтууд байгаа бөгөөд одоог хүртэл тулгараад буй асуудлуудыг шийдэх боломж нээлттэй хэвээр л байна.

Өөр нэгэн чухал асуудал болох Интернэтийн хэрэглээ нь тэр тусмаа хөгжлийн зорилгоор ашиглах боломж нь мөн шийдэх асуудлууд олонтой салбарын нэг юм. Интернэтийн засаглалын форум юу хийж чадах вэ гэвэл эдгээр асуудлуудыг шийдэх шилдэг аргачлалыг боловсруулан гаргах явдал билээ. Интернэтийн засаглалын чадавхийг бэхжүүлэх нь бүх улс орны Засгийн газрууд хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа билээ.

Ажлын хэсгийн төгсгөлийн тайлангийн талаар хэлэлцүүлэг нь Интернэтийн засаглалын асуудлууд хэр чухал болох талаар ихээхэн мэдлэг бий болгосон юм. Тухайн асуудлуудыг шийдэхэд цаг хугацаа шаардлагатай зэрэгцээ олон улсын хэмжээний хэлэлцүүлгүүдийг ч хийх хэрэгтэй байгаа билээ. Ийм төрлийн чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаа нь зөвхөн олон улсын харилцаатай хамаарах асуудал ч бус. Интернэтийн засаглалд тулгараад буй ихэнх асуудал нь орон нутгийн чанартай бөгөөд эдгээрийн дундаас МХХТ-ийг хөгжлийн зорилгод ашиглах нь ихээхэн чухал болоод байна. Энэ шалтгааны улмаас улс орнуудын Засгийн газрууд нь Интернэтийн засаглалын үйл ажиллагаанд ихээхэн чухал үүрэгтэй байх юм.


Интернэтийн засаглалын тухай энэхүү модуль нь доорх асуудлуудыг тусгасан болно:

1. Интернэтийн засаглал нь Интернэтээс илүү өргөн хүрээг хамрах асуудал билээ. Энэ нь Интернэттэй холбоо бүхий зарим олон улсын харилцааны улс төрийн асуудлууд, Интернэтийн хэрэглээ болон хүчирхийлэл, нийгэм- эдийн засгийн хөгжлийн зорилгод Интернэтийг ашиглах зэрэг олон асуудлыг хамарч байгаа билээ.
2. Түгээмэл байдаг буруу ойлголтыг үгүйсгэх шаардлагатай бөгөө учир нь Интернэт нь язгуур бүс хэмээх төвлөрсөн хяналтын системтэй байдаг. Энэхүү систем нь АНУ-ын Засгийн газрын харьяа Интернэтийн нэр, дугаар олголтын корпорацын мэдэлд байдаг.
3. НҮБ-аас байгуулсан Интернэтийн засаглалын ажлын хэсэг нь Интернэтийн засаглалтай холбоотой улс төрийн асуудлуудыг шийдэх зорилготой байсан билээ. Үйл ажиллагаа явуулсан эцсийн тайландаа Ажлын хэсэг нь Интернэтийн засаглалын форумыг байгуулсан ч язгуур зоны систем нь АНУ-ын Засгийн газрын мэдэлд хэвээр үлдсэн бөгөөд харин ccTLDs –тэй холбоотой асуудлууд дээр улс орнуудын Засгийн газрууд өөрийн хяналтаа хадгалан үлдээсэн.
4. Интернэтийн засаглал нь олон салбарыг хамарсан, олон талын оролцоот байх ёстой. Ямар нэгэн улс орон дангаараа Интернэтийг засаглах тал дээр дангаар ажиллах боломжгүй байх ёстой билээ. Мөн олон улсын болон улс орнуудад явагдаж буй үйл явц нь ардчилсан шинжтэй байх шаардлагатай. Олон улсын түвшинд Интернэтийн засаглалд оролцох оролцоог бүх орнуудад нээн өгч бүх шатандаа засаглалын хуувийн хэвшил, иргэний нийгмийн салбарт өргөтгөх шаардлагатай.
5. Оффлайн хэрэглээний адил Интернэтийг гурван шатаар дамжуулан зохицуулж болох бөгөөд үүнд хууль зүй, нийгмийн хэм хэмжээ, зах зээлийн механизм болон архитектураар нь дамжуулан зохицуулж болно. Интернэт дээр хуулийн хэрэгжилтийг хангах нь тэр болгон хялбар бус тул Засгийн газрууд нь Интернэтийн зохицуулалтдаа ихээхэн бүтээлч байдлаар хандах хэрэгтэй.
6. Чөлөөт зохицуулалт нь төрийн зүгээс хийх зохицуулалтын нэг хэлбэр билээ. Энэхүү хувилбарыг Интернэтийн зохицуулалтын чухал хэлбэр хэмээн үздэг бөгөөд харин үүнд хэрэглээ болон зардлын тал дээр зарим хязгаарлалт, сул талууд байдаг.
7. Интернэтийг зохицуулах ерөнхий төлөвлөгөө нь мөн өөр нэгэн үр дүнтэй аргуудын нэг билээ.
8. Интернэт нь хуучин гэмт хэргүүд шинээр амьдарч эхлэх орон зайг бий болгосны зэрэгцээ шинэ төрлийн гэмт хэргүүдийг бий болгосон билээ. Эдгээрийн эсрэг хууль хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэлийн нэг нь тухайн гэмт хэргийг тодорхойлох асуудал байдаг.
 - а. Дэлхий нийтийн тэмцэх зайлшгүй шаардлагатай хэмээн нийтлэг зөвшилцөлд хүрсэн хоёр салбар нь хүүхдийн порнограф болон хэрэглэгчдийг залилах гэмт хэргүүд билээ. Эдгээр гэмт хэргийг мөрдөн шалгахад хууль сахиулах байгууллагууд идэвхтэй хамтран ажиллаж байгаа.
 - б. Спам, скам болонаюултай код болон фишинг зэрэг нь дэлхий нийтээр зохисгүй хэрэглээнд тооцогддог ч улс болгонд эдгээрт хамаарах хууль байхгүй.
 - в. Кибер хүчирхийлэл, доромжлол болон мэдээллийн хулгай, Интернэтд донтох талаарх зохицуулалтын хувьд харилцан адилгүй байгаа.
 - г. Интернэтийн засаглалын форум нь тодорхой бүлгүүд эвсэл болон нэгдэл тодорхой нэгэн асуудлаар үйл ажиллагаа явуулах боломжийг нээж өгсөн.

9. Зохицуулалт нь бүтээлч байхын адилаар шийтгэл ч мөн адил бүтээлч байх ёстой.
10. Интернэтээр дамжуулан үйлдэж буй гэмт хэрэгтэй тэмцэхэд олон улсын хамтын ажиллагаа ихээхэн чухал.
11. Интернэтийн засаглалын асуудлууд нь оффлайн ертөнцөөс ч халин гарч буй бөгөөд үүний жишээнд өрсөлдөөний бодлого, цензур болон үг хэлэх эрх чөлөө, нэр хүнд гутаах, зохиогчийн эрх болон оюуны өмчийн эрхийн асуудал, хувийн нууцлал зэрэг хамаарч байна.
12. Интернэтийн засаглалын талаарх судалгаагаар хөгжиж буй орнууд мэдээллийн эдийн засгийн хувьд хоцрогдоод байгааг илрүүлжээ. Тиймээс МХХТ-ийг хөгжлийн зорилгод ашиглах нь Интернэтийн засаглалын нэгэн хэсэг юм.
 - а. МХХТ-ийг хөгжлийн зорилгоор ашиглахад тодорхой саад тотгор, хүндрэлүүд байдаг.
 - б. Даган дуурайж, хэрэгжүүлж болох амжилтын түүхүүд ч байгаа.
 - в. МХХТ-ийг хөгжлийн зорилгоор ашиглах нь ил тод байдлыг сайжруулах зэргээр засаглалыг сайжруулахад өөрийн хувь нэмрээ оруулна.
13. Интернэтийн засаглалын улс төрийн асуудлууд нь шийдэгдээгүй байгаа бөгөөд энэхүү асуудалд орон бүрийн Засгийн газар анхаарлаа хандуулах ёстой.

Зураг 3. Зохиогчийн эрхийн тэнцлийн хууль

Эх сурвалж: DiploFoundation, <http://textus.diplomacy.edu/textusbin/env/scripts/Pool/GetBin.asp?IDPool=1190>.



ХАВСРАЛТУУД

НЭМЭЛТ МАТЕРИАЛ

Ang, Peng Hwa. 2005. Ordering Chaos: Regulating the Internet. Singapore: Thomson.

Butt, Danny, ed. 2005. Internet Governance: Asia-Pacific Perspectives. Bangkok: UNDP-APDIP. <http://www.apdip.net/publications/ict4d/igovperspectives.pdf>.

Cukier, Kenneth Neil. 2005. Who Will Control the Internet? Foreign Affairs November/December. <http://www.foreignaffairs.org/20051101facomment84602/kenneth-neil-cukier/who-will-control-the-internet.html>.

Drissel, David. 2006. Internet Governance in a Multipolar World: Challenging American Hegemony. Cambridge Review of International Affairs 19(1), March, 105-120.

Kapur, Akash. 2005. Internet Governance: A Primer. Bangkok: UNDP-APDIP. <http://www.apdip.net/publications/iespprimers/eprimer-igov.pdf>.

Working Group on Internet Governance. 2005. Report of the Working Group on Internet Governance. <http://www.wgig.org>.

Wu, Tim, Esther Dyson, A. Michael Froomkin and David A. Gross. On the Future of Internet Governance. American Society of International Law Proceedings of the Annual Meeting, Vol. 101. <http://ssrn.com/abstract=992805>.

Glossary

IP Address	Internet Protocol address: a unique identifier corresponding to each computer or device on an IP network. Currently there are two types of IP addresses in active use. IP version 4 (IPv4) and IP version 6 (IPv6). IPv4 (which uses 32 bit numbers) has been used since 1983 and is still the most commonly used version. Deployment of the IPv6 protocol began in 1999. IPv6 addresses are 128-bit numbers.
Registrar	A body approved ('accredited') by a registry to sell/register domain names on its behalf.
Registry	A company or organization that maintains a centralized registry database for the TLDs or for IP address blocks (e.g. the RIRs — see below). Some registries operate without registrars at all and some operate with registrars but also allow direct registrations via the registry.
RIRs	Regional Internet registries. These not-for-profit organizations are responsible for distributing IP addresses on a regional level to Internet service providers and local registries.
Root servers	Servers that contain pointers to the authoritative name servers for all TLDs. In addition to the 'original' 13 root servers carrying the Internet Assigned Numbers Authority-managed root zone file, there are now large number of Anycast servers that provide identical information and which have been deployed worldwide by some of the original 12 operators.
Root zone file	Master file containing pointers to name servers for all TLDs.
WHOIS	A transaction oriented query/response protocol that is widely used to provide information services to Internet users. While originally used by most (but not all) TLD Registry operators to provide 'white pages' services and information about registered domain names, current deployments cover a much broader range of information services, including RIR WHOIS look-ups for IP address allocation information.

СУРГАГЧ БАГШ НАРТ ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

Дээрх “Модулийн тухай” хэсэгт дурдсанчлан энэхүү модуль болон бусад цуврал нь олон төрийн уншигч нарт хандсан, улс бүрийн нөхцөлд тохирлуулан хэрэглэгдэх юм. Модулиуд нь бүрэн болон хэсэгчилсэн байдлаар ашиглагдаж болох бөгөөд мөн онлайн болон оффлайн нөхцөлд хамаарч болно. Модулийг хувь хүмүүс, бүлгүүд болон сургалтын байгууллагууд ч ашиглаж болох бөгөөд мөн төрийн байгууллагууд ч ашиглах боломжтой. Оролцогчдын мэргэжил, суурь мэдлэг болон сургалтын үргэлжлэх хугацаа нь мөн харилцан адилгүй байж болно.

Энэхүү тэмдэглэл нь энэхүү модулийн сургалтыг явуулахад зориулан хэрэглэх зарим санаа болон зөвлөгөөг агуулсан байгаа. Сургалтын талаарх зарим хандлага болон стратегийг үүнд зориулсан тусгай гарын авлага дээр тусган оруулсан. Энэхүү гарын авлагыг <http://www.unapcict.org/academy> хаягаар үзэж болно.

Модулийг ашиглах нь

Бүлэг болгон нь суралцах зорилтуудыг дурдсанаар эхэлсэн бөгөөд төгсгөл болгонд нь шалгах асуултуудыг оруулсан. Уншигчид эдгээр зорилтууд болон асуултуудыг харьцуулан ашиглах боломжтой. Бүлэг болгон мөн хэлэлцэх асуултууд болон дасгалыг агуулсан нь бие даан сурагчид болон сургагч нарт зориулагдсан болно. Эдгээр асуулт, дасгал нь уншигч нар өөрийн туршлага дээрээ үндэслэн агуулгыг тусган авах болон тухайн асуудлуудад үр дүнтэй хариулт олоход зориулагдсан билээ.

Кейс судалгаа нь мөн нэгэн чухал хэсэг нь билээ. Эдгээр нь дүн шинжилгээ, хэлэлцүүлэгт ашиглагдах ба модульд тусгагдсан гол үзэл баримтлалын талаарх бодит жишээг харуулсан байгаа. Интернэтийн засаглалын кейсүүд дээрх асуудлууд нь олон улсын болон орон нутгийн түвшнийх байгаа. Орон нутгийн түвшинд МХХТ болон Интернэтийн хэрэглээг бий болгох зорилгоор ихээхэн ажил хийгдэж байгаа билээ. Сургагч нар нь өөр бусад кейсийг гаргах хүсэлтийг тавин тэднийг бүтээлчээр ажиллуулж болно.

Хичээлийн бүтэц

Оролцогчдоос болон цаг хугацаанаас хамааран энэхүү модулийн агуулгыг янз бүрээр боломжит цагт багтаан тайлбарлаж болно. Интернэтийн засаглалын талаар зарим хэмжээний шинэ мэдээлэл өгөх шаардлага бүхий төрийн байгууллагын өндөр албан тушаалтнуудад энэхүү сургалтын хугацааг богиносгон 2-3 цагт багтааж болно. Бүрэн хэмжээний сургалт нь 1.5 өдөр шаардана. Энэхүү модуль нь эхний гурван бүлэг нь анхан шатны суурь мэдлэг, дараагийн бүлгүүд нь хэрэглээний талаар суралцах зорилгоор боловсрогдсон билээ.

1-2 цагийн сургалт

Бүлэг 1 болон 2-ийг нийлүүлэн дэлхийн дээд хэмжээний уулзалт болон ажлын хэсгээс гарсан үр дүн дээр голлоно. Мөн Бүлэг 6-аас МХХТ-ийг хөгжлийн үйл ажиллагаанд хэрэглэх хэсгийг оруулна.

Гурван цагийн сургалт

Бүлэг 1 болон 2-ийг нийлүүлэн, оролцогчдоос хамааруулан 3, 4, 5 болон 6 дугаар бүлгийг нийлүүлэн дээр нь нэмээд -

- Эрх зүйн орчныг бий болгох буюу бүлэг 4 болон 5-аас оруулах;
- МХХТ-ийг хөгжлийн зорилгод ашиглах буюу бүлэг 5 болон 6-аас оруулах,

Бүтэн өдрийн сургалт (6 цаг)

Бүлэг 1, 2 ба 3-ийг өглөө судлана. Үдээс хойш Бүлэг 4, 5 болон 6-г хэлэлцэн, дасгал болон асуултуудыг нь ашиглан хэлэлцүүлэг явуулна. Энэ нь хоолны дараа хүмүүсийн идэвхийг сэргээнэ. Бүлэг 7-гоор сургалтыг дуусгана.

1.5 өдрийн сургалт

Хэдийгээр нийт 7 хичээл байгаа ч үргэлжлэх хугацаа нь өөр өөр. Хамгийн гол нь бүлгийн зорилгод ихээхэн мэдрэмжтэй байх хэрэгтэй бөгөөд энэ нь тухайн оролцогчид сургалтаас юу сурахыг хүсэж байгаатай нь нийцүүлэх ёстой гэсэн үг. Бүлэг 1 ба 2 нь үндсэндээ суурь мэдлэг олгох талаар байгаа. Хэрэв оролцогч бүлэг нь энэ талаар сонирхохгүй бол дараагийн хэсгээс буюу үр дүнгээс эхлүүлж болно. Ерөнхийдөө оролцогч нар илүү практик ур чадварыг хүсэж болох юм. Хэлэлцүүлэг болон мэдээлэл хуваалцах зэргээр үүнийг хангаж болно.

3 хоногийн сургалт

Эхний өдөр Бүлэг 1 ба 2-ийг хэлэлцэнэ. Суралцагчдын бүлэг ямар сэтгэгдэлтэй байгаагаас хамааран Бүлэг 3-ийг эхлүүлж болно. Дараагийн өдөр нь Бүлэг 3, 4 ба 5-ийг судлах ба сүүлийн өдөр нь 6, 7-г хэлэлцэнэ. Оролцогч нар өөрийн туршлагаа ч ангид хуваалцах боломжтой байх ёстой. Ялангуяа оролцогч нар Бүлэг 6-г ашиглан өөрийн улс дахь тоон хуваагдлын асуудлуудыг хэлэлцэх хэрэгтэй. Бүлэг 7 нь улмаар бүх бүлгийг нэгтгэн дүгнэх боломж олгоно.

ЗОХИОГЧИЙН ТУХАЙ

Ан Пен Хуа нь Сингапурын Наньян технологийн их сургуулийн Вий Ким Вий харилцаа холбоо, мэдээллийн сургуулийн Интернэтийн судалгааны төвийн захирал, профессороор ажилладаг. Мэргэжлийн хуульч тэрээр хэвлэл мэдээллийн хууль, бодлогын хичээл заадаг бөгөөд Интернэтийн засаглалын чиглэлээр судалгаа хийдэг. 2005 онд бичсэн Эмх цэгцгүй байдлыг зохицуулах нь хэмээх номондоо тэрббээр Интернэтийн зохицуулалтын талаар дурдсан байна.

2004 онд тэрээр НҮБ-ийн ЕНБД-ын тушаалаар Интернэтийн засаглалын ажлын хэсэгт орж ажиллан 2005 оны Дэлхийн мэдээлэлжсэн нийгмийн дээд хэмжээний уулзалтын тайланг бэлтгэн гаргажээ. Мөн дараа нь тэр Дэлхийн Интернэтийн засаглалын судлаачдын сүлжээг үүсгэн байгуулахад хувь нэмрээ оруулсан байна.

Одоо тэрээр Акийн хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны төвийн захирлаар ажиллаж байна. Тэрээр мөн Энэтхэгийн Ахмедабадын Мудрагийн харилцаа холбооны хүрээлэнгийн удирдах зөвлөлд ажилладаг.

UN-APCICT- НҮБ-ын Хөгжлийн төлөөх МХХТ-ын Ази, Номхон далайн бүсийн төв

НҮБ-ын Хөгжлийн төлөөх МХХТ-ын Ази, Номхон далайн бүсийн төв нь (UN-APCICT) НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн хорооны (ESCAP) салбар юм. UN-APCICT-ийн зорилго нь хүний, институтын чадавхи бүрдүүлэх, улмаар нийгэм эдийн засгийн хөгжилд МХХТ-ыг ашиглах зорилгоор хорооны гишүүн улсуудын хүчин чармайлтыг нэмэгдүүлэхэд оршдог ба дараах гурван гол багана дээр тулгуурладаг:

1. Сургалт. Бодлого боловсруулагч болон МХХТ-ын мэргэжилтнүүдийн МХХТ-ын мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх, МХХТ-ын сургагчид, институтуудын чадавхийг сайжруулах;
2. Судалгаа. МХХТ-ын хүний нөөцтэй холбоотой аналитик судалгааг явуулах;
3. Зөвлөгөө. Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн хорооны гишүүн болон холбогдох гишүүдэд хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт зөвлөгөө өгөх.

UN-APCICT нь БНСУ-ын Инчеон хотод байрладаг.

<http://www.unapcict.org>

ESCAP- АНДБ-ийн Эдийн засаг, Нийгмийн Хамтын Ажиллагааны байгууллага

ESCAP бол НҮБ-ын бүс нутгийн хөгжлийн төв бөгөөд Ази, Номхон далайн бүсийн НҮБ-ын эдийн засаг, нийгмийн хөгжлийн төв нь болж явдаг. Зорилго нь 53 гишүүн, 9 холбогдох гишүүдийн хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх. Тус байгууллага нь глобал, олон улсын түвшний хөтөлбөрүүд болон асуудлуудын хоорондын стратегийг холбох гүүр болон ажилладаг. Энэ нь бүс нутаг дахь засгийн газруудад глобалчлагдаж буй дэлхийд бүс нутгийн давтагдашгүй нийгэм-эдийн засгийн сорилтуудтай тулгарахад өөрийн байр сууриа хадгалж үлдэх, бүс нутгийн хандлагаар тусламж үзүүлдэхэд оршино. Төв нь Тайландын Бангкок хотод байрладаг.

<http://www.unescap.org>

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН МХХТ-ИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙН АКАДЕМИ

<http://www.unapcict.org/academy>

Сургалт нь 8 модультай бөгөөд хөгжлийн төлөөх МХХТ-ын өргөн хүрээний сургалтын хөтөлбөр болж, гол зорилго нь бодлого боловсруулагчдыг чухал шаардлагатай мэдлэг, ур чадвараар хангаснаар үндэсний хөгжлийн зорилгуудад хүрэх, тоон хуваагдлыг арилгахын тулд МХХТ-ын боломжуудыг хөшүүрэг болгон ашиглах явдал юм.

Модуль 1- МХХТ-ийн хэрэглээ болон бодит хөгжлийн харилцан хамаарал

МХЗ-уудыг хангахын тулд МХХТ-г хэрэглэхэд бодлогоос хэрэгжүүлэлт хүртэл гол асуудлууд болон шийдвэрийн санаануудыг онцлон тэмдэглэсэн.

Модуль 2- Хөгжлийн бодлого, үйл явц, засаглалд зориулсан МХХТ

Хөгжлийн төлөөх МХТ-ын бодлого боловсруулах, засаглал дээр төвлөрөн хөгжлийг дэмжих үндэсний бодлого, стратегиуд, үндсэн бүтцүүдийн талаар чухал мэдээлэл олгоно.

Модуль 3- Цахим засгийн хэрэглээнүүд

Цахим засгийн ойлголтууд, зарчмууд, хэрэглээний төрлүүдийг тайлбарладаг. Энэ нь мөн хэрхэн засгийн газрын систем бий болсон болон зохиомжийн асуудлуудыг тодорхойлдог.

Модуль 4- Төрийн албан хаагчдад МХХТ-ийн хөгжлийн чиг хандлагуудыг танилцуулах нь

МХХТ-ын одоогийн чиг хандлага, ирээдүйн чиглэлд гүнзгий ойлголт өгөх. Энэ мөн МХХТ-ын шийдвэр гаргахад гол техникийн болон бодлогын асуудлыг авч үздэг.

Модуль 5- Интернэтийн засаглал

Интернэтийн хэрэглээ, үйл ажиллагааг зохицуулах олон улсын бодлогууд болон процессуудыг одоогийн үргэлжилж буй хөгжлийг авч үздэг.

Модуль 6- Сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал, нууцлал

Мэдээллийн аюулгүй байдлын асуудлууд, чиг хандлагууд, мэдээллийн аюулгүй байдлын стратеги боловсруулах процессуудыг авч үзнэ.

Модуль 7- МХХТ-ийн төслийн удирдлагын онол болон практик

Хөгжлийн төлөөх МХХТ-той холбоотой төслийн удирдлагын үзэл баримтлалуудыг тайлбарлах, түүн дотроо аргууд, үйл явцууд, нийтлэг хэрэглэгддэг төслийн удирдлагын зарчмуудыг авч үзнэ.

Модуль 8- Хөгжлийн төлөөх МХХТ-ийн санхүүжилтийн хувилбарууд

Хөгжлийн төлөөх МХХТ-д болон цахим засгийн төслүүдэд зориулсан санхүүжилтийн сонголтуудыг эрж хайх. Төр-хувийн хэвшлийн түншлэл нь хөгжиж буй орнуудын хамгийн хэрэгтэй санхүүжилт гэж онцлон тэмдэглэгддэг.

Эдгээр модулиуд нь Академийн хамтрагчдийн кейс судалгааны дагуу өөр өөр улс орны бодлого боловсруулагчдын шаардлагатай нийцэх, түүнтэй хамааралтай байх зорилгоор шинэчлэн сайжруулагдсан. Модулиуд нь тухайн улс орны хэл дээр орчуулагдана. Цаашлаад, эдгээр модулиуд нь бодлого боловсруулагчидтай тэдний хамааралтай байдлыг хангах зорилгоор тогтмол шинэчлэгдэж, шинэ модулиудыг 21-р зуунд зориулсан МХХТ-иудыг үндэслэн боловсруулна.

Виртуал Академи (AVA – <http://ava.unapcict.org>)

- Академид зориулсан онлайн зайн сургалтын орчин
- Бүх Академийн модулууд түүн дотроо виртуал лекцүүд, слайдууд болон жишээнүүдэд онлайнгаар хандах боломжтой
- Суралцагчдыг өөрсдийн байгаа газраасаа суралцах боломжийг нээж өгсөн

Цахим хамтын ажиллагааны төв (e-Co Hub – <http://www.unapcict.org/ecohub>)

- Хөгжлийн төлөөх МХХТ-ын мэдлэг хуваалцах, нөөц материалуудын портал
- Модулаар нөөцүүдэд хялбар хандах боломжийг олгодог
- Хэрэглэгчид онлайн хэлэлцүүлэгт оролцож, e-Co Hub-ийн онлайн бүлгийн гишүүн болж, хөгжлийн төлөөх МХХТ-ын мэдлэгээ нэмэгдүүлэх, хуваалцах боломжтой.

AVA болон e-Co Hub-дахь үйлчилгээг авах сонирхолтой байвал доорхи хаягаар бүртгүүлнэ үү.
http://www.unapcict.org/join_form